

НҮҮДЭЛЧДИЙН ХОЁР ТӨРИЙН ХААДЫН УГ ЭХИЙН ДОМГУУДЫН ҮНЭН МАГАД ТҮҮХИЙГ НЯГТЛАХ НЬ

Г. МЭНЭС

*МУИС-ийн Гадаад хэл соёлын сургууль, Түрэг судлалын төв,
Menes_g@chinggis.com*

Түлхүүр үгс: Тэнгэрийн нагац, Хүннү, Маодунь, Хуянь, Хияд яс, Боржигин овог, Алтан ураг

Өгүүллийн товч агуулга: Эл судалгаагаар Хүннү улсын шаньюй хийгээд Их Монгол улсын Хияд яст Боржигин овогт Чингис хааны Алтан ургийн эзний язгуур гарсан уг эхийн түүхийн үнэн магадыг нягтлахын тулд холбогдол бүхий эртний Хятадын болон Монгол сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн ирсэн домгууд, угсаатан судлалын эх хэрэглэгдэхүүнийг мөшигин шинжилсний үндсэн дээр бид Хүннү улсын эзэн буюу шаньюйн ураг хийгээд олон Монголчуудын дотроос тодорхой нэгэн угсаатны бүлэг буюу Хиян яснаас угшилтай Боржигин овгийнхны эрхэм шүтээн болж ирсэн язгуур өвөг буюу тотем нь Гэндү буюу эр чоно байсан тухай нэлээд ноцтой үндэслэл бүхий ойлголттой боллоо. Монгол угсаатны чоно шүтэн бишрэх үзэлд чоноос удам угсаагаа залган тоолох нь ямагт эцгийн тал буюу ясаа барьж хөөдөг уламжлал нэлээн тод томруун мэдэгдэж байгаа учир Хүннүгийн эзэн шаньюйн урагтай Хияд ястай Монголын хаадын ураг л худ ураг болж ирсэн байж болох нь учир зүйн бүрэн үндэслэлтэй гэж үзэж байна.

1. ХҮННҮ УЛСЫН ЭЗНИЙ УРАГ: УГ ЯЗГУУР ГАРСАН ТҮҮХЭНД ХОЛБОГДОЛ БҮХИЙ НЭГЭН ДОМГИЙГ НЯГТЛАХ НЬ

Зөвлөлтийн эрдэмтэн судлаачдын дундаас Хүннү улс иргэнийг түрэг хэлтэн байсан гэсэн үзэл баримтлалыг ихээхэн хөхиүлэн дэмжиж ирсэн цуцашгүй урам зоригтны нэгэн бол археологич А.Н. Бернштам байсан билээ. Тэрбээр 1926 оноос эхлэн бүр 1956 он хүртэл олон тооны эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэн нийтлүүлсэн бөгөөд тэдгээр ном зохиолдоо түүний тогтолцоот үзлийн тулгын чулуу болсон Хүннү болон эртний Түрэгүүдийн тотем шүтлэг бишрэлийн тухай нэгэн үзэл санаа дэвшүүлсэн нь онцгой анхаарал татсан юм. Ерөнхийдөө энэхүү үзэл санаа бол Хүннүг Түрэг хэлтэн хэмээн үздэг хуучны үзэл онолын нэгэн хувилбар гэж үзэж болно. Харин одоо энэхүү үзэл нь В.С. Таскины шүүмжлэлээс хойш бараг мартагдахад хүрсэн гэж хэлж болно.

Гэхдээ шинжлэх ухааны үнэн ёсыг эрхэмлэн үзвэл, Хүннүгийн угсаа гарлын асуудлыг бараг уламжлал болгон хэлний шинжлэлийн талаас шийдэх арга барил

бүрэн ноёрхож байсан судалгааны орчин нөхцөлд Хүннүгийн тотемыг сэргээн нягтлах гэсэн цорын ганц үзэл санаа нь Хүннүгийн түүх болон соёлын судалгаанд шинэлэг бөгөөд үр бүтээл бүхий чиглэлийн эхийг тодорхойлон тодотгож өгөх байсан болов уу гэж бид санаж байна.

Энэхүү судалгааны чиглэлийн түүхийг эргэн санавал ийн буюу. А.Н. Бернштам Хүннү улс иргэний эзэн шаньюйн ураг ясны тотемыг сэргээн нягтлахдаа, Маодунь шаньюй Хуянь (Нū-уān 呼延) хэмээх Хүннүгийн язгууртан ястай байсан гэдэгт нут итгэсэнд хэргийн гол оршиж байгаа юм. Учир нь, А.Н. Бернштам Хүннүгийн угсаа гарлын түүхийг нягтлан сэргээхдээ энэхүү баримт мэдээг тулгын чулуу болгон эш татсаны үндсэн дээр ихээхэн хэтрүүлэгтэй дүгнэлт хийсэн боловч уг баримт мэдээ нь алдаа мадагтай болохыг ерөөсөө ч гадарлаагүй ажээ.

А.Н. Бернштам судалгааныхаа гол үндэслэлийг Рашид ад-Дин, Хондемир, Абу-л-гази нарын зохиолд дахь Түрэг болон Перс гар бичмэлийн Түрэг 24 аймгийн домогт язгуур өвөг болох Огуз хааны намтартай Хүннүгийн Маодунь шаньюйн намтартай тун төстэй байгаа гэсэн таамаглал дээр тулгуурлажээ (Рашид ад-Дин, 1952: т. 1, кн.1, 85; Кононов, 1958: 50-51; Бернштам, 1959: 224-235). Гэхдээ А.Н. Бернштамын энэхүү санаа бол анх дэвшүүлэн тавигдаж буй санаа хэрхэвч биш юм. Огуз хааны болон Маодунь шаньюй хоёрын намтар тун төстэй болохыг анх Н.Я. Бичурин анхааран тэмдэглэсэн ажээ (Бичурин, 1959: т.1, 56-57).

Гэхдээ, А.Н. Бернштамын таамаглалын онцлог гэвэл, тэрбээр өөрийн үзэл санаагаа хөгжүүлэхдээ хоёр намтрын ижил төстэй байдлыг тэмдэглэснээр хязгаарласангүй, харин ч энэхүү сэдвийг лавшруулан боловсруулснаар түрүү түрүүчийн судлаач нараас цааш явжээ.

Гэвч А.Н. Бернштамын энэхүү судалгаа бол Зөвлөлтийн эрдэмтдээс тус сэдвийг археологийн болон хэл шинжлэлийн мэдээ баримт дээр тулгуурлан дахин шинээр ухааран боловсруулан нотлох оролдлого хийгдэх үед дэвшүүлэн тавьсан цорын ганц бөгөөд сүүлчийн судалгаа байсныг бас тэмдэглэлгүй өнгөрч болохгүй. А.Н.Бернштам дараахь таамаглалыг үндэс болгожээ.

Нэгт, Хараагийн Ноён ууланд малтан судалсан булшууд дундаас олдвороороо ихэд баялаг байсан 6-р булшийг А.Н. Бернштам “Учжулю жоди” шаньюйн оршуулга гэж таамаглан үзсэн байна; **Хоёрт**, Учжулю жоди шаньюйн уг язгуур нь Хүннү гүрнийг үндэслэн байгуулсан Тоумань болон Модэ шаньюй нарын алтан ураг болох Хуянь яс байжээ гэж А.Н. Бернштам бас нэгэн таамаглал дэвшүүлжээ; **Гуравт**, Ноён уулын 6-р булшаас бухын дүрс бүхий хоёр мөнгөн товруу олджээ (**Зураг 1**). Энэ хоёр олдворын үндсэн дээр Хүннү улс иргэний алтан ураг нь бух тотемтой байжээ гэсэн нэгэн өвөрмөц таамаглалыг бас дэвшүүлсэн байна; **Дөрөвт**, Хуянь гэдэг үгийн хятад дүрс үсгийн эртний дуудлага нь (x)uo᠒ā᠒ гэсэн хэлбэрээр уншигдах бөгөөд энэ дуудлагаас түрэг хэлний “o᠒uz” болон түүний эртний хэлбэр болох монгол хэлний “ūker” гэдэг үг үүсэн гарсан гэсэн эцсийн таамаглалаа дэвшүүлсэн байна (Бернштам, 1946: 83-84).



Зураг 1.

А.Н. Бернштамын энэхүү хэт хийсвэр таамаглал хийгээд зохиомол нотолгоо баримтын тогтолцоог Зөвлөлтийн нангиадач В.С. Таскин нягтлан үзсэн байна.

В.С. Таскины тэмдэглэснээр, Маодунь шаньюй нь Хуянь ястай байсан тухай А.Н. Бернштамын таамаглал нь сурвалж бичгийн мэдээ баримтаар ерөөсөө ч батлагдахгүй зөрөлдөж байгаа аж. Тухайлбал, "Хань шу" ["Хан улсын түүх"] (ХШ, 94а бүлэг, 7а тал) хэмээх хятадын эртний сурвалж бичигт мээ II-I зууны түүхч Сыма Цяны "Ши цзи" ["Түүхийн тэмдэглэл"]-д байхгүй 45 дүрс үсэг бүхий нэгэн сонирхолтой хэсэг бий. Энэ дашрамд тэмдэглэхэд, тус хэсэг байхгүй учраас Сыма Цяны тэмдэглэн оруулсан Хүннү гүрний нийгмийн шат давхарга нь шаньюй байх тэргүүн хэсэггүй болж алдарт түүхчийн тэмдэглэл нь бүрэн бус авцалдаагүй болгоход хүргэсэн байна. Тус хэсэг нь ийн буюу: "Шаньюй Люаньди яснаас уг язгууртай. Түүнийг тэдний улсад "Чэнли гуду шаньюй" хэмээн нэрлэдэг. Сюнну нар тэнгрийг чэнли, харин хөвүүнийг гуду хэмээмуй. Шаньюй [гэдэг үг] нь өргөн гэсэн утга заах бөгөөд энэ цол хэргэмийг зүүсэн нь Тэнгэр мэт өргөн уудам болохыг харуулна" ["Шаньюй происходит из фамилии Люаньди. В их государстве его именуют "Чэнли гуду шаньюй." Сюнну называют небо чэнли, а сына называют - гуду. [Слово] шаньюй означает "обширен подобно Небу"] (Таскин, 1968: 129-130,133).

Тэрчлэн, мээ 40-50-иад оны үеийн өмнөд Хүннү нарт холбогдол бүхий хэрэг явдлыг тэмдэглэн оруулсан "Хоу Хань шу" ["Зүүн Хан [улсын] түүх"] (ХХШ, 89 бүлэг, 7б тал)-гийн бүлэгт бидний сонирхон бүхий асуудалд холбогдох баримт мэдээг ийн тэмдэглэжээ: "Шаньюйн уг язгуур бол Сюйлянйи яснаас гаралтай байсан бөгөөд бусад яснаас Хуянь, Сюйбу, Цюлинь болон Лань буй. Эдгээр дөрвөн яс нь сюнну улс дотроо ихэд нэр хүнд бүхий яснууд байсан бөгөөд шаньюйтай байнга худ ураг болцогоодог байсан ажээ" ["Шаньюй происходил из фамилии Сюйлянйи, а из других фамилий имелись Хуянь, Сюйбу, Цюлинь и Лань. Эти четыре фамилии являлись в государстве сюнну наиболее знатными родами и постоянно вступали в брачные связи с шаньюем"] (Таскин, 1973: 73).

Энэхүү эртний хятадын сурвалж бичгийн хоёр мэдээ баримт нь Маодунь шаньюй (мээ 209-174) тэргүүтэй Хүннүгийн бүх шаньюй нарын уг язгуур нь А.Н.Бернштамын таамаглан ойлгож байснаар Хуянь яс биш, харин *Сюйлянйи* (хү-líán-tí 虛連題) буюу аль эсхүл арай өөрөөр товчилсон бололтой галигласан *Люаньди* (luán-dí 攣鞬) ястай байсныг магад тодорхой зааж байна. Зөвхөн энэ хоёр мэдээ баримт нь Хүннүгийн шаньюйн ургийн уг язгуурын тухай А.Н.Бернштамын үзэл санаа, таамаглал болон нотолгоо бүхий тогтолцоо нь дээсэн дөрөө дээр тогтож байсныг харуулж байна (Таскин, 1968: 129-130).

Харин Монголын эрдэмтэн Ч. Далай, Г. Сүхбаатар нар луу, чоно, бух (сарлаг?), буга (марал) зэрэг амьтад болон домгийн хийсвэр дүр нь Хүннү нарын шүтээн бөгөөд тэднийг язгуур өвөг дээдэс мэтээр төсөөлдөг тухай бичсэн нь угтаа мөн л Хүннүчүүд бух тотемтай байсан тухай Н.А. Бернштамын үзэл санааны нөлөө мөн бололтой (Далай, 1959: 9; Сүхбаатар, 1980: 75, 130, 177). Учир нь, тэд Хүннү нарын тотемийн талаар тодорхой таамаглал гаргасан боловч ямарваа нэгэн баримт нотолгоо болон мэдээ занги зэргийг эш татан гаргасангүй.

Ер нь, энэ дашрамд тэмдэглэхэд, эрдэм шинжилгээний ном зохиолд Хүннү, эртний Түрэгүүд, Уйгур болон дундад зууны Монголчууд бүгд нэг л чоно тотемтой байсан тухай таамаглал үзэгдэх нь цөөнгүй болжээ. Судалгааны иймэрхүү маягийн

баримжаа чиглэл үүсэн бий болсон нь даруй тус асуудлыг ерөөсөө ч нарийн нягт задлан шинжилж байгаагүйг гэрчлэн харуулах баримт болой.

Тэгтэл, зарим судлаачид зөвхөн Түрэг олон ястан угсаатнууд л чоноос уг язгууртай байсан гэсэн хэтрүүлэг таамаглал дэвшүүлээд түүнийхээ үндсэн дээр бүхэл бүтэн ном зохиол турвин бичиж хэт өргөн цар хүрээтэй дүгнэлт хийхийг эрмэлзсээр иржээ. Ганцхан жишээ болгон Буриадын эрдэмтэн Д.С. Дугаровын бүтээлийг эш татан үзэхэд хангалтай мэт. Тэрбээр, буга (марал), хун шувуу, чоно зэрэг амьтад бол Монголчуудынх биш, харин Сака болон эртний Түрэгүүдийн шүтэн биширдэг язгуур амьтад байсан нь тодорхой гэсэн дүгнэлт таамаглал дэвшүүлэхээс гадна “марал”, “бюрю”, “кува” гэдэг нэрс нь угтаа Монгол биш, харин Түрэг үгс юм гэсэн бас нэгэн таамаглал гаргасны үндсэн дээр Монголын Боржигин овог, ер нь Нирун аймгийн бүрэлдэхүүнд багтаж байсан угсаатны бүлгүүд болон хожмын Буриадын ихэнх овог яс нь Түрэг гарал угтай байсан юм биш үү гэсэн дүгнэлт хийжээ (Дугаров, 1983: 47-49).

Монголчууд хийгээд Түрэг ард түмний чоны тухай иймэрхүү чиглэлийн санал бодол нь салангад таамаглал төдий байх бөгөөд дэлгэрэнгүй тайлбар сэлтгүй болон нотолгоо баримтгүйгээс гадна тэдгээр саналууд нь өөр хоорондоо төдийлөн их ялгахдахгүй нэг нэгийгээ дагасан байдал нь Монгол хийгээд Түрэг угсаатны түүх, соёлд холбогдох ихэнх судалгааны зохиолуудын тулгын чулуу болж ч байсан, одоо ч болсоор байна. Иймээс, тэдгээр олон зохиолуудыг дахин нягтлан үзэх чухал шаардлага байхгүй гэж үзэж болно.

Харин тэмдэглэвэл зохистой нэгэн зүйл гэвэл, тотемийн үзэл хийгээд тотемийн домгийн мөн утга учир нь үнэн хэрэг дээрээ цус ясан төрлөөр уг язгуур нэгтэй болох бүлэг улс иргэнийг нэг л тотем өвөг дээдэстэй, тэр тотем нь бусад язгуур гарваль өөр бүлэг иргэнд байхгүй, тиймээс тэдгээрийн уг эхийн түүх домог, угсаа гарваль тэс өөр болохыг онцлон сануулахад оршдог байна (Токарев, 1964: 53, 68). Иймээс, тотемийн үзлийн тулгын чулуу болсон энэхүү утга учрыг баримталбал, Хүннү, Түрэг, Уйгур хийгээд Монголчуудыг нэгэн чоно тотемтой байсан гэдэг үзлийг баримтлагч эрдэмтдийн эх үндэс болсон таамаглал нь хэр үндэслэлтэй болох нь ойлгомжтой бөгөөд тэд түүхэн бодит мэдээ баримтыг хэрхэн нягтлан үзсэн буюу үздэг эсэх нь тодорхой ба тэдний үзэл санаа болон дүгнэлт нь мөн л эргэлзээ төрүүлэх нь дамжиггүй гэлтэй.

Бидний санахад, чоно тотемийн тухай эдгээр таамаглалууд нь бүрэлдэн бий болоход эртний хятадын сурвалж бичигт тэмдэглэгдэн ирсэн нэгэн домог багагүй нөлөө үзүүлсэн байж болох юм. Эл домог нь мэ 551 оны үед Вэй Шоу хэмээх түүхчийн зохиосон “Вэй шу” [“Вэй [улсын түүх”] гэдэг судрын 103-р бүлэгт тэмдэглэгдэхээс гадна бас “Бэй ши” [“Умардын түүх”] гэдэг ойллого бичгийн 98-р бүлэгт тэмдэглэгдэн хадгалагджээ. “Вэй шу” судар нь мэ 386 оноос 538 он хүртэл Хятадын умард нутагт Монгол уг язгуурт Сяньбичуудын Тоба хэмээх нэгэн аймгийн байгуулсан “Их Вэй” улсын төрийн түүх юм (Сүхбаатар, 1971: 7). “Вэй шу” судрыг анх 130 бүлэгтэй зохиосон бөгөөд харин хожим алдагдаж үрэгдсэн учир түүнийг Умард Сүн улсын үед “Бэй ши” судрын үндсэн дээр түүхч Люй Шу, Фань Цзу-юй нар дахин бичиж сэргээсэн түүхтэй ажээ (Сүхбаатар, 1971: 7).

Харин тус домгийн орчуулгын тухайд гэвэл, бид эн тэргүүнээ Оросын нэр өндөр нангиадач Н.Я. Бичурин (Иакинф)-ы орчуулгыг эш татах нь зүйн хэрэг гэж үзлээ. “Вэй шу” хэмээх төрийн түүхийн 103-р бүлгийн Ойхор буюу Уйгур улс иргэний тухай хэсэгт, мээ III-II зууны үед холбогдох нэгэн үйл явдлыг ийн

өгүүлжээ: “Гаогюй нь үндсэндээ Чи-ди хэмээх эртний овгийн удам юм. Тэд анхандаа Дили гэгдэж байсан. Харин умар зүгт Гаогюйн динлин гэгддэг болсон. Тэдний хэл Хүннү хэлтэй төстэй, гэхдээ жаахан ялгаа бий. Зарим хүмүүсийн ярих нь, Гаогюй ургийн өвөг дээдэс нь Хүннү урагийн зээгээс гаралтай гэдэг. Хүннү улсын шаньюйгийн дэргэд бусын үзэсгэлэнт хоёр охин төрсөн гэж ярьдаг. Улсын түшмэд тэднийг тэнгэрийн охид гэж бодох ажээ. Шаньюй хэлсэн нь: “Ийм охидыг хүнд өгч болох уу? би тэдний тэнгэрт өргөө”. Чингээд улсынхаа нийслэлээс умардад зэлүүд газар өндөр асар босгон, түүндээ охидоо суулгаад: “Тэнгэр минь, охидыг минь таалан соёрхоно уу” хэмээн мөргөжээ. Гурван он өнгөрсний хойно эх нь охидоо эргүүлэн авья гэхэд шаньюй: “Болохгүй, цаг нь болоогүй” гээд эс зөвшөөрөв. Үүнээс хойш дахин нэг он болоход нэгэн хөгшин чоно ирж асрыг өдөр шөнөгүй харуулдаж, улих болсон гэнэ. Улмаар асрын доор үүр ухаж ороод түүнээсээ ер гарахаа больжээ. Дүү нь: “Эцэг маань биднийг тэнгэрт өргөхөөр энд суулгасан билээ. Гэтэл эдүгээ энэ чоно ирсэн нь магадгүй тэнгэрийн бэлгэ тэмдэг биз ээ” хэмээн хэлээд доош бууж түүн дээр очих гэтэл эгч нь маш их цочин: “Энэ чинь адгуус шүү дээ! Эцэг эхийн нэрийг бүү гутаа!” гэжээ. Дүү нь эгчийнхээ үгэнд оролгүй доош бууж чонын гэргий болж хөвүүн төрүүлж өгөв. Тэдний хойчис өсөн үржсээр хожим улс болжээ. Ийм учраас эндхийн хүмүүс чоно лугаа адил улин уртын дуу дуулах дуртай ажээ” (Бичурин, 1950: т. 1, 214-215).

Энэ домгийн түүхэн утга агуулгын тухай Н.Я. Бичурин: “Ойхорын [хойху] улс нагацын талаас хүннүгээс удамласан гэж хятадын түүхэнд бичдэг. Иймээс, ойхор [хойху] улсыг үндэслэгч нь дили овгийн холбоонд холбогдох эзэн ноёд өгсөн хүннүгийн ханы охин, аль эсхүл зээ охины хүү болох нь эргэлзээгүй зүйл юм” гэж тайлбарласан байна (Бичурин, 1950: т.1, 213).

Энэхүү домгийг Зөвлөлтийн нангиадач В.С. Таскин арай өөрөөр ийн орчуулжээ: “Гаоцзюй нь эртний чиди-гийн салбар салааны үлдэгдэл бололтой. Тэд анхандаа дили гэж нэрлэгдэж байсан, умардад тэднийг чилэ гэж дууддаг байхад хятадад бол гаоцзюй динлин (өндөр тэрэгт динлин). Тэдний хэл ерөнхийдөө хүннүтэй төстэй, гэхдээ заримдаа бага зэрэг ялгаа тохиолдоно. Гаоцзюйн язгуур дээдэс нь сюннугийн [шаньюй]-гийн зээ юм гэж заримууд нь ярьдаг. Тэдний салбар салаанд Диши, Бяохэши, Хулюйши, Цзепиши, Хугуши болон Ицициньши зэрэг овгууд багтадаг. Ард түмний аман яриа ёсоор, сюннугийн шаньюйгийн хоёр охин төрсөн бөгөөд тэр хоёр ер бусын үзэсгэлэнтэй учир улс иргэн нь тэднийг тэнгэрийн охид гэж бодох ажээ. Шаньюй хэлсэн нь: “Нэгэнт надад ийм охид байгаа учир би тэднийг [эгэл жирийн] хүнд өгч болох уу? Би тэднийг тэнгэрт өргөө”. Чингээд улсынхаа умардад хүнгүй газар өндөр дэвсэг босгон: “Тэнгэр минь! охидыг минь таалан хүлээн авна уу” хэмээн мөргөж түүндээ охидоо суулгав. Гурван оны дараа эх нь охидоо хүлээн авья гэхэд шаньюй: “[Үүнийг хийж] болохгүй, тэд нүүн суух [ёстой]” гээд эс зөвшөөрөв. Дахиад нэг он болоход нэгэн хөгшин чоно ирж дэвсгийг өдөр шөнөгүй харуулдан улих болсон гэнэ. Тэр дэвсгийн доор үүр ухаж ороод түүнээсээ ер гарахгүй байсаар байжээ. Тэгтэл дүү охин нь: “эцэг маань намайг тэнгэрт өргөхөөр энд суулгасан билээ. Гэтэл өнөө энэ чоно ирсэн нь магадгүй тэнгэрийн явуулсан шидэт амьтан биз” хэмээн хэлжээ. Тэгээд доош чоно руу очих гэтэл эгч нь маш ихэд цочин: “энэ чинь адгуус шүү дээ! Эцэг эхийн нэрийг гутаах болно” гэж хэлжээ. Гэвч дүү нь эгчийнхээ үгэнд оролгүй доошоо буугаад чонын гэргий болж хөвүүн төрүүлж өгөв. Хожим түүний үр хойчис өсөн үржээд нэгэн улс байгуулжээ. [Учир иймээс] энэ улсын хүмүүс чоно лугаа адил улин сунжруу урт дуу дуулах дуртай дуртай ажээ” (Материалы..., 1984: 401).

Ийнхүү бид хятад сурвалж бичгийн мэдээ болон Н.Я. Бичурины орчуулсан тайлбар сэлтээс үзвэл, тус домог нь Уйгур төр улсыг үндэслэн байгуулагч нэгний уг эхийн түүхийг эрт үеэс өнөө үе хүртэл хэрхэн тайлбарлаж байсныг мэдэж авлаа. Мөн эл домогт тус улсын дуун урлагийн нэгэн онцлог болох чоно мэт улин дуулдаг болсон учир шалтгааныг заасан домог орсон байгаа нь гойд сонирхолтой мэдээ бөгөөд энэ асуудлыг бид дараачийн хэсэгт хэлэлцэх болно.

Энэхүү домог нь Хүннү, Түрэг, Уйгур болон Монголчуудын угсаа гарлын асуудлыг сонирхон судалж байсан эрдэмтдийн анхаарлыг ихэд татаж байсан билээ. Гэхдээ тэд тус домгийг магад үнэн түүхийн эх сурвалж гэж үздэггүй байсан учраас түүний дотор агуулагдаж буй түүхэн мэдээг тэр болгон нарийвчлан нягталж байсангүй бололтой.

Учир байдал иймээс, бид Хүннүгийн эзний ургийн уг язгуур болох тотем дүрийг тодруулан гаргаж, улмаар Хүннүгийн угсаа гарлын асуудалд гэгээ оруулах асуудалтай холбогдуулан тус домогт агуулагдаж буй угсаа гарлын тухай мэдээ баримтын түүхэн утга учрыг задлан гаргахын тулд дараахь онцлог гогцоо шижмүүдийг анхааран үзье.

Нэгт, тус домгийн агуулгыг ерөнхийд нь авч үзвэл, түүний гол утга санаа нь Хүннү улс иргэний эзэн шаньюйн охин чонотой гэр бүл болсноор нэгэн улсын язгууртан угсааны уг эхийн түүхийг тайлбарласан учир тус домогт ямарваа нэгэн бодитой болж өнгөрсөн түүхэн хэрэг явдал тусгалаа олсон бололтой;

Хоёрт, Хүннү улс иргэний эзний бага охин нь чонотой гэр бүл болсныг хоёр харь овог яс худ ураг болсон гэж үзэж болох юм;

Гуравт, Хүннүгийн эзний ураг нь чонын удмынхантай нэг бус удаа буюу ихээхэн тогтсон худ урагийн харилцаа холбоотой байсан бололтой. Учир нь, худын талынхныг бодитой хүн биш, харин шаньюйн охиныг гуйж буй бүхэл нэгэн ураг ясны тотем болох чоноор төлөөлүүлсэн бололтой;

Дөрөвт, хүүхэн гуйж буй талынхны төлөөлөгч болох чоныг „хөгшин” гэсэн хоршоо үгтэй тэмдэглэн оруулсан нь тус амьтан нь үнэн хэрэг дээрээ нэгэн тодорхой овог яс, ургийн язгуур дээдэс байсан болов уу? гэсэн бидний таамаглалыг бататган өгч байна;

Тавд, Хүннүгийн шаньюй нь хоёр охиноо эрд гаргахдаа хүнд буюу эгэл жирийн хүнд өгөлгүй тэнгэрт өргөөд түүний дараа худ ураг болох хэрэг явдал нь хөгшин чонотой холбогдох болсныг нягтлан үзвэл, тэр чоно тэнгэрийн амьтан байжээ гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, чоно тотемтэй байсан ураг яс нь тэнгэр гаралтай байжээ гэж үзэж болно;

Зургаад, Хүннүгийн шаньюй „чэнли гуду” буюу “тэнгэрийн хүү” байсан учир түүний охид мөн тэнгэр гаралтай болох нь лавтайгаас гадна тэнгэр гаралтай охидтой тэнгэр гаралтай л ураг яс худ ураг болох нь ойлгомжтой гэлтэй;

Долоод, дээр дурьдсан мэдээ баримтыг үндэслэвэл, Хүннүгийн шаньюйн ураг нь харь шири болох Чонын урагтай худ урагийн холбоотой байсан бөгөөд шаньюйн ураг лавтайяа чоныг эрхэмлэн шүтэж өөрийн тотем болгож байгаагүй нь тодорхой баримт болой.

Бидний сонирхон бүхий домгийн утга учрыг нягтлан оролдсоноор тус домог нь түүх, угсаа гарлын талаар гойд сонирхолтой эх сурвалж болох нь тодорхой учир Монгол болон Түрэг угсаатны язгуур гарлын нэгэн асуудлын талаар тодорхой

хариулт өгч болох мэт санагдаж байна. Тухайлбал, тус домгоос нягтлан гаргасан Чоно тотемтой холбогдол бүхий түүх угсаа гарлын мэдээ баримтыг түшиглэвэл, Хүннү улс иргэний эзний ургийг Чоно тотемтой байсан гэгддэг эртний Түрэгүүд болон Монголчуудтай шууд холбоон үзэх үндэс байхгүй болж байгаа юм. Мөн бид Хүннү улс иргэний эзний ураг нь Чоно тотемтой байгаагүй гэдэг баримтыг хүлээн зөвшөөрвөл Хүннүүчүүдийг зөвхөн энэхүү үзэл санаагаар Түрэг хэлтэн үү? Аль эсхүл Монгол хэлтэн байсан уу? гэдэг асуудлыг шийдэх бол судалгааны үндэс суурьгүй болсныг тодорхой зааж байна. Гэхдээ, бидний энэ санаа бол нийт Хүннүгийн дотор Чоно тотемтой ураг байгаагүй гэсэн санаа хараахан биш гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Хүннү нийгмийн дотор тотемийн тухай үзэл бодол нэгэн янз төрхтэй байгаагүй нь мэдээж хэрэг бөгөөд эзэд язгууртны хоорон дахь худ ургийн хэлбээ холбоо бидний төсөөлж ирсэн үзэл бодлоос арай өөр буюу нарийн утга учиртай байсан бололтой. Энэхүү асуудлыг шийдэхийн тулд дараагийн бүлэг асуудлаа авч үзье.

2. МОНГОЛЫН АЛТАН УРАГ ХИЯД ЯСТ БОРЖИГИНЫ УГ ЭХ: ТЭНГЭРИЙН НОХОЙ БУЮУ МОНГОЛЧУУДЫН НЭР ЦЭЭРЛЭН НЭРЛЭХ УЛАМЖЛАЛ

Ийнхүү бид Хүннү улс улсын эзний ургийн үүсэл гарвалын домгийг нягталж үзсэнээр, тэдний язгуур хэрхэн гарсан тухай ихээхэн тодорхой ойлголттой боллоо гэж санаж байна. Гэвч иймэрхүү ойлголт мэдлэгтэй болсноор бид дараагийн хоёр асуултыг зайлшгүй тодруулан шийдэх хэрэгтэй боллоо. Тодруулбал, нэгт, археологи, түүх, аман зохиолын болон бусад эх сурвалжийн мэдээг баримтыг нягталж магадласнаар Хүннүгийн шаньюйн хүргэний ургийн үүсэл гарвалын тухай домгийг өөр нэгэн ураг буюу угсаатантай холбон хэлэлцэх боломж хэр буй? Хэрвээ тийм боломж байгаа бол чухам ямар ураг буюу угсаатан ястантай холбон нягталбал зохистой вэ? гэсэн хоёр асуулт тавигдах нь зүйн хэрэг гэж үзүүштэй.

Бидний санахад, Хүннүгийн шаньюйн урагтай эртний нүүдэлчдийн чухам аль төр улсын эзэн хааны ураг ч атугай бүр тодорхой нэг цул угсаатны дотор чухам аль бүлэг нь худ ураг болж байсныг ихээхэн баримттай хэлж өгч чадах хэд хэдэн ноцтой мэдээ заалт өнөө бидний үе хүртэл уламжлагдан ирсэн байна. Тухайлбал, бидний “Захчин ясны угсаа гарал, аж ахуй, оюуны болон эдийн соёл” сэдвээр угсаатан зүйн хээрийн судалгааны аман мэдээ тэмдэглэн авах явцад нэгэн сонирхолтой домгийг сонссон нь тэдгээр мэдээний нэг болой. Тэр домгийг 1927 онд Алтай суманд төрсөн Захчин ястай Осорын Дашдорж гуай бидэнд 1987 оны зун Ховд аймгийн Булган сумын төвд өгүүлсэн нь ийн буюу: “Бурхан багш дуу түгээгээд дууссаны дараа Торгуудад дуу хоносон байна. Захчин, Урианхай, Дөрвөд, Өөлдөд дуу нь үдэлж ирсэн байна. Ийм учраас, Захчин дуугаа нам дуугаар дуулдаг. Дуу дууссаны дараа Халх ирж “дуу хайрлаач” гэж бурхан багшаас гуйжээ. Дуу олдохгүй байх үед чоно улихад нь чонын дуутай адил дууг Халхад өгсөн байна” (Мэнэс, 1987 : 129-130).

Энэхүү домгийг Монголын эрдэмтэн С. Дулам 1983 онд мөн О. Дашдорж гуйгаас тэмдэглэн авч нийтлүүлснийг дурьдах хэрэгтэй. Тэр тэмдэглэн авсан хувилбарт өгүүлсэн ёсоор: “...дууны эзэн монгол газраар явж байхдаа торгууд нарын дунд хонож өнжсөн учраас торгууд дууны ая их уужим, уянгалуу урт байдаг, захчин нарын дунд үдэлж, үдийн хугас болсон тул захчин дуу богино огцом аятай байдаг” гэжээ (Дулам, 1989: 148).

Бидний тэмдэглэн авсан домгийг “Вэй шу” судар бичиг дэх домогтой харьцуулан үзвэл, энэхүү хоёр домгийн нийтлэг нэгэн өгүүлэмж нь Монгол угсаатны дууны урлагийн оргил болсон “уртын дууг” чонин улих дуутай холбож үзсэн хэрэг бол угтаа байгаль ертөнцийн эд юмс, үзэгдэл хийгээд хүнтэй холбоотой соёл дэвшлийн ололт амжилтыг тайлбарлах утга агуулга бүхий хэсэг юм. Учир иймд, энэхүү домог нь домог зүйн сэтгэлгээний үр хөврөл мөн бөгөөд тэр нь Монгол угсаатны соёлын хүрээ дотор бүрэлджээ гэсэн таамаглал тавигдах нь зүйн хэрэг юм.

Харин энэ таамаглалтай холбон эрдэмтдийн анхааралд хараахан өртөгдөөгүй байгаа Монголын түүхч Г. Сүхбаатар аbugайн хятад сурвалж бичигт уртын дуу гэдэг хоёр үгийг дүрс үсгээр хэрхэн бичин тэмдэглэж ирсэн тухай нэгэн сонин саналыг эргэж үзэх хэрэгтэй болов уу. Г. Сүхбаатар аbugайн тэмдэглэснээр, “Вэй шу” сурвалж бичигт дэх чонын улих лугаа адил урт дууг хятадаар “чан гэ” гэдэг дүрс үсгээр тэмдэглэсэн бөгөөд “чан” нь урт, “гэ” нь дуу юм. Иймээс, “чан гэ” гэсэн нь “урт дуу” гэсэн нэрийн хуулга орчуулга гэмээр байна гэсэн санал дэвшүүлсэн байна (Сүхбаатар, 1980: 134).

Иймд, угсаа гарвалын тайлбар талаас авч хэлэлцвэл, Төв Азийн нүүдэлчдийн соёлын хүрээ дотор уртын дууны уламжлалыг хадгалж ирсэн гол угсаатан болох Монголчуудын дунд хүртэл Халхчуудын уртын дууны онцлогийг чонин улих дуугаар тайлбарласан нь онц сонирхолтой баримт мэдээ гэж үзүүштэй.

Нөгөө талаар, Халхчуудын уртын дууны үүслийн тухай домгийн өгүүлэмж нь Монголчууд буюу тодруулбал Халх угсаатан нь чоноос уг язгууртай гэсэн тотемийн утга агуулга бүхий үзлийн улбаа байж магадгүй гэж таамаглан үзсэнээс бидний сонирхол бас үүдэлтэй гэдгийг хэлэх хэрэгтэй юм. Уг асуудлын утга учир нь угсаа гарвалын тайлбарын талаас иймэрхүү чиг баримжаатай байж болохыг, тухайлбал, Чингис эзний Алтан ургийн язгуур өвөг дээдэс Бөртэ Чино гэдэг хүний нэрийн утга хийгээд Боржигин гэдэг гэдэг овгийн нэрийн утга учир тус бүртээ зааж байгаа гэж бид сананам.

Харин судлаачид монгол хэлний “Боржигин” болон “Бөртө” гэдэг хоёр үгийн гарлыг мөшгин шинжихдээ, “Боржигин” нэрийн эхний “Бор”- нь монгол хэлний “Бору” гэсэн өнгө заасан үгтэй гарал утгын холбоотойг тогтоогоод, дундад үеийн монгол хэлний “Бору” нь цайвар бор, бор саарал, хөхөлбөр бор, саарал гэсэн утга илтгэж байсныг сурвалж бичгийн мэдээгээр нотлон харуулжээ (Очир, 1983: 99-100). Түүнчлэн, түрэг хэлний “Бөри” (“Бүри”) гэсэн үгтэй дуудлага болон утгаар нь дүйлгэж болох “Бөртө” гэдэг монгол үг байх бөгөөд тэр нь “бор толбот” гэсэн утгатай ажээ. Бөртөндөх гэвэл бор толбо нь ихдэх, бор толботой болох, бор сэвх суухыг хэлнэ (Очир, 1983: 100). Судлаачдын үзсэнээр, эрт цагт алтайн хэлнээ чоныг “Бөри” (“Бүри”) гэж нэгэн адил нэрлэж байсны үлдэц бол Монголчууд хожим хүртэл чонын бэлтрэгийг “Бөрт” гэж нэрлэж байсан тухай Лувсанданзаны “Алтан товчийн” мэдээ гэрчлэн зааж байгаа бөгөөд “Бөри”, “Бору” хоёр үг гарлын холбоотой болохыг зааж байна. Мөн түрэг хэлний “Бөри” (“Бүри”), монгол хэлний “Бору” гэсэн үгс угтаа алтайн хэлнээ нэг язгуур гаралтай, ойролцоо утгатай байгаад хэлний хөгжлийн цаашдын явцад утга нь салбарлан холдохын зэрэгцээ авианы хувьсал үзсэн бөгөөд “Бөри” (“Бүри”) нь эртний хэлбэрээ илүү хадгалж, “Бору” нь утга болон авианы бүтцийн хувьд нэлээд өөрчлөгджээ гэсэн дүгнэлт хийжээ (Очир, 1983: 100).

Иймд, өмнөх судлаачдаас, тухайлбал “Бөртэ” гэдэг үг нь монгол хэлний “Чино” гэдэг үгийн Түрэг хэлнээс зээлдэн авсан хуулга гэсэн санал нь эргэлзээтэй буюу ташаа болохыг энэхүү хэл шинжлэлийн нягт судалгааны үр дүн харуулж байна (Цыдендамбаев, 1972: 277-279).

Харин чоныг ураг төрлийн хэлхээ холбооны хүрээнд олон Монголчуудын дунд бус, Халхчуудын дунд ч бус, зөвхөн эзэн Чингис хааны харьцангуй явцуу болох Алтан ургийн дотор чухам ямар утгаар хүлээн авч үзэж байсныг харуулсан хоёр мэдээ заалт бас буй.

Нэг дэх мэдээ заалтын тухайд гэвэл, Чингис хаан Тангад улс руу дайлаар мордох зуураа Хангай ханд их ав тавьжээ. Тэр ав тавих үед Чингис хаан нэгэн онцгой хоригийг авын хүмүүст зарлиг болгосон байна. Тэр зарлигийн ёсоор, авын хүрээнд нэгэн хоа марал, нэгэн бөртэ чоно хоёулаа орно. Түүнийг амьд гарга, бүү ал гэж хатуу хоригложээ. Энэ хориг нь утга агуулгаараа энгийн боловч сайтар нягталбал, бидний дээр тавьсан асуудалд холбогдох хэдэн мэдээ заалт байгаад чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, авын хүрээнд орсон ан амьтдаас зөвхөн чоно, марал хоёрыг алахыг хориглосон байна. Зарлиг буулгахдаа ав хомрогод орсон бүх чоно болон марал биш, зөвхөн Бөртэ чоно, Хоа марал хоёр амьтанг алж агнахыг хориглосон нь сонин байна. Тэр хоёр амьтны нэрийн утгыг анхаарвал, “Монголын нууц товчоон”-ы эхний хоёр мөр дотор бичигдсэн Чингис хааны удам угсааны эцэг эх хоёр талын язгуур өвөг дээдсийн нэрс болох нь бас нэгэн сонин баримт мөн болой. Гэхдээ, Чингис хааны авын энэ хоригийн тухай ямарваа нэгэн мэдээ сэлт “Монголын нууц товчоон”-д байхгүй, харин нэлээд хожуу үеийн сурвалж бичгүүд болох “Хураангуй Алтан товч” (1604-1627), гүүш Лувсанданзаны “Алтан товч” (1634-1655), Саган сэцэний “Эрдэнийн товч” (1662-1663), Галдан туслагчийн “Эрдэнийн эрих” (1841) зэрэг сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэн нь бас л сонин баримт юм (Qad-un..., 2002: 54; Алтан товч, 1957: 141; Saγan..., 1961: 120-121; Galdan, 1960: 43).

Тэрчлэн, дундад зууны Монголчууд, тэр дотроо Алтан ургийнхан чоныг хэрхэн үзэж байсныг Чингис хааны хүү Өгэдэй хаанд тохиолдсон нэгэн түүхээс гадарлаж болно. Тэр түүхэнд өгүүлсэн ёсоор: “Менгли-Бука гэгч сүрэг хоньтой нэгэн монгол хүн байжээ. Нэгэн удаа шөнөөр тэр сүрэгт нь чоно ороод ихэнхийг нь хядсан байна. Маргааш өдөр нь монгол хүн эрхэм дээд төрөлт дээр бараалхаж хонин сүрэг болон чоны тухай хэрэг явдлыг илтгэсэн ажээ. “Тэр чоно хаа холдох вэ?” гэж хаан хэлж гэнэ. Тэр үед тэнд тохиолдлоор лалын бөхчүүд тэр нутагт барьж авсан нэгэн чонын амыг нь боон хөтлөн явж байжээ. Хаан тэднээс чоныг мянган балышаар худалдан аваад монгол хүнд: “Чи түүнийг алснаар чамд ямар ч ашиг гарахгүй” гэж хэлээд түүнд мянган хонь тасалж өгөхийг тушаажээ. “Энэ чоныг сул тавья. Өөрийн нөхөддөө энэ нутгаас зайлан одохыг тэр хэл хүргэг” гэж хаан хэлсэн байна. Тэгээд чоныг суллан тавьтал түүнийг ноход барьж аваад тасар татжээ. Энэ хэрэг явдалд хаан хилэгнэн уурсаж, ноходоос чонын өшөөг аваахыг тушаасан байна. Гунигтай бөгөөд бодлогоширсон тэрбээр ордныхоо дотоод өрөө рүү ороод сайд болон шадар хүмүүстээ хандан ийн хэлжээ: “Чоныг суллан тавихын учир ийн буюу. Би миний биед нэгэн гэм өвчин байгааг олж мэдсэн ба тэгээд хэрвээ би ямарваа нэгэн амьтныг үхлээс ангижруулбал мөнх тэнгэр надад эдгэрэхийг соёрхон хайрлах болов уу гэж би бодсон. Гэвч тэр тэдний савраас амь мултарч чадаагүй учраас би ч гэсэн мэдээж ангалаас гарахгүй нь... Хаад нь тэнгрийн таалалтан болох нь нууцлагдаагүй буюу тэд хэрэг явдлын байдлыг мэдсэн байхын тулд тэдэнд тэнгрийн мэлмий нээх нь бас тохиолддог юм” [“Был один монгол по имени Менгли-Бука; было у него стадо овец.

Однажды ночью на то [стадо] напал волк и погубил большую его часть. На следующий день монгол пришел к его величеству и доложил о происшествии со стадом и волком. Каан сказал: “Куда [же] волку уйти?”. В это время там случайно ходили борцы-мусульмане и водили живого волка со связанной пастью, которого они поймали в тех краях. Каан купил у них того волка за тысячу балышей и сказал монголу: “От того, что ты [его] убьешь, тебе не будет никакой пользы”, – приказал дать ему тысячу баранов. “Отпустим этого волка, – [сказал каан], – пусть он предупредит своих братьев, чтобы они уходили из тех пределов”. Когда волка отпустили, на него напали собаки и растерзали его. Каан по этому случаю разгневался и приказал отомстить собакам за волка. Печальный и задумчивый ушел он во внутренние покои ставки и сказал, обратившись к вельможам и приближенным: “Цель освобождения волка заключалась в следующем. Я обнаружил в состоянии своего здоровья некоторую слабость и подумал, что если я дам избавление какому-нибудь животному от гибели, то предвечный бог дарует мне исцеление, но так как он не спасся от их лап, то, конечно, я тоже не выйду из пропасти. Не сокрыто, что государи – избранники божьи и что для них случаются божественные откровения, дабы они были осведомлены о [положении] дел” (Рашид ад-Дин, 1960: т. II, 63).

Бидний эш татсан Өгэдэй хааны амь амьдралын нэгэн агшинг өгүүлсэн энэхүү түүхийн доторх чонотой холбоотой өгүүлэмж нь Хияд яст Боржигин овогт Чингис хааны Алтан ургийн язгуур өвөг дээдсийн буюу тотемийн шүтээнтэй чухам ямар шижим холбоотой болох бөгөөд энэ өгүүлэмжийн утга учрыг чухам ямар маягаар, аль талаас нь ухвал зүйтэй вэ? гэдэг асуултад хариу өгөхөд тийм ч амаргүй санагдаж болох юм. Гэхдээ, эдгээр асуултын хариуг угсаатан зүйн судалгааны эх хэрэглэгдэхүүнээс олж мэдэж болох мэт санагдана. Тухайлбал, угсаатан зүйч Ц. Аюушийн тэмдэглэсэнээр: “Халхчуудын аман домог, элдэв ёс, зан үйлд чоно агнах, чононоос мал сүргээ хамгаалахтай холбогдох аж ахуйн шүтлэгийн чоныг домгийн өвөг дээдсээ болгон тотемчилох эртний үзэл төсөөллийн үлдэц ч бас дайралдана. Аян жин, адуу малын эрэл сураг зэрэг алив ажил үйлст зорьж гэрээс гарч явах үедээ чоно тааралдахыг чоно мөрт сайн, үйл бүтнэ хэмээн бэлэгшээдэг. Чоно мал сүрэгт орох, мал идэхийг төдий л гай гарз болгон үздэггүй, харин ч “чонын ам өөдрөг, хулгайн гар хар” хэмээн хулгайн явдлаас дээгүүр тавин үздэг байв.

Чоныг тотеми өвөг дээдсээ болгон үзэх төсөөлөл тогтдоггүй хүүхэдтэй холбоотой нэлээд зан үйлд уламжилж үлдсэн нь огт санамсаргүй зүйл биш бололтой. Энэ нь юуны өмнө тотеми өвөг дээдсийн аль нэг зүйл ер бусын хүч чадалтай байдаг мэтээр үзэх, тотеми амьтантайгаа цусан төрлийн холбоотой байдаг гэсэн ойлголтын холын ул мөр байж болох юм. Жишээ нь, тогтдоггүй хүүхэдтэй айл хүүхдийн хүйг чонын шөрмөсөөр боож авах, чоны шаа, хоншоорыг хүүхдэд зүүхийг сайн гэж үзэхийн зэрэгцээ бас чоны арьсанд боож авах, улмаар буруу үүдээр айлд өгч Шаалуу, Бэлтрэг гэдэг нэр өгвөл хүүхэд осолддоггүй гэхчлэн ярьж, заримыг нь багагүй дагаж баримталсаар явжээ.

Тотеми амьтныхаа нэрээр тодорхой овог элгэн өөрсдийгөө нэрлэх ёс дэлхийн ард түмнүүдэд элбэг байдгийн нэгэн адил халхчуудын овог ясны нэрэнд чонон тотемийн нэр бас уламжилсан байна. Тухайлбал, Архангай аймгийн Жаргалант сумын Асайтын голоор нутаглах бүлэг халхчууд яс угаа “чоно бүртийнхэн”, “бүртийнхэн” гэхчилэн нэрлэсээр ирсэн нь ихээхэн сонирхолтой мэдээ юм.

Чоно тотемитой холбоотой өөр нэгэн сонин баримт бол монголчуудын тав, ёсон зоосны мэрэг төлгөнд хадгалагдаж үлдсэн чоныг онцгойлон үзэх өвөрмөц заншил юм. Зоосоор мэргэлэхэд 5, эсвэл 9 зоосыг зайлсны дараа алган дээрээ дугуйруулан цувруулж тавих ба ийм тохиолдолд нар, сар, уул, хэрээ, чонон, арслан гэх мэтээр газар дэлхий, од гариг, амьтдаар төлөөлүүлэн нэрлэсэн зооснууд тодорхой дэс дарааллаар байрлах бөгөөд үүнийг “зоосны хөл” гэж нэрлэдэг. Зоос төлөөлүүлж буй юмс хийгээд амьтныг хар, цагаан гэсэн өнгөөр ялган хэлэлцэх ба цагаан өнгө нь алив ажил үйл бүтэмжтэй, хар өнгө нь түүний эсрэг юм. Гэвч “зоосны хөл”-нд хар, цагаан аль ч зүсмийн чоно, ялангуяа цагаан чоно буухыг ихэд бэлэгшээн үзэж, элдэв ажил хэрэг бүтэмжтэй, хэл сураг сайн байдаг гэх мэтээр бүх л өөдрөг сайн бүхнийг холбон төсөөлдөг нь мөн л чоныг тотемчилох, түүнийг дээдчилэн үздэг монголчуудын өнө эртний сүсэг бишрэлийн улбааны илрэл болох нь эргэлзээгүй.

Үүнээс гадна халхын анчид, ер нь нийт монголчуудын дунд их дэл үстэй, цагаан зүстэй чоныг “тэнгэрийн чоно” хэмээн онцгойлж, түүнийг алахыг ихэд цээрлэдэг байсан нь дээр өгүүлснийг нотолж буй гэлтэй” (БНМАУ-ын..., 1987: 399-400).

Энэ дашрамд дурдахад, Монголчуудын чоныг язгуур дээдэс гэж үздэг тотемийн уламжлалын асуудалтай холбогдуулан Баруун Буриадын нэгэн угсаатны бүлэг болох Эхиридүүд нь чоноор тэжээгдсэн Чоно гэгч нэртэй хөвүүний үр удам учир тэднийг чоно ургийнхан (“чонородские”) гэж овоглон дуудах болсон тухай нэгэн домог бас буй (Михайлов, 1980: 74). Бидний санахад, энэ домгийн утга агуулга нь Монгол угсаатны балар эртний үеийн домог зүйн сэтгэлгээнээс эх сурвалжтай Чоно тотемийн үзэл санааны улбаа мөр ихэд удаан хадгалагдаж ирснийг зааж буй хэрэг бололтой.

Бидний санахад, Халхчуудын чоныг шүтэн бишрэх зан үйл, ёс горим, домог ярианы тухай ихээхэн баримттай угсаатны зүйн судалгааны мэдээ сэлт нь Хияд яст, Боржигин овогт Өгэдэй хааны чоныг суллан тавьж тэр чонон нь нохойд тасар уруулсанд хилэгнэсэн зэрэг тэрхэн мөчид болж өнгөрсөн сэтгэл санаа уймарсан ноцтой байдлын утга агуулгыг бидэнд ерөнхийд нь ойлгуулж байгаа боловч түүний нарийн эгзэгтэй учир шалтгаан нь Халхчуудын зоосны мэрэг төлгөнд чоныг зүс хамааралгүй бэлэгшээн үзэж бүтэх сайн бүхнийг холбон үздэг сүсэг бишрэлтэй холбоотой бололтой. Өөрөөр хэлбэл, Өгэдэй хаан өөрийн бие нь сайнгүй байгааг мэдээд түүний үр дагаврыг мэдэхийн тулд тэр үед санамсаргүй таарсан чоныг худалдан авч суллан тавьсан нь угтаа мэрэг төлгийн утга агуулгатай байсан буюу сулласан чоныг ноход тасар татсан нь муу ёрыг ёрлосон бэлгэдэлт хэрэг явдал болсон учир түүний өвөг дээдэс язгуурын эрт үед чонооос уг гаралтай гэсэн өгүүлэмжтэй домог яриаг сонсож мэддэг байсан хүний хувьд ийнхүү сэтгэл санааны хямралд орсон байж магадгүй юм.

Дээрх баримт мэдээг нэгтгэн дүгнэвэл, Халхчуудын урт дууг чоно улих лугаа адилтган заасан Захчины домгийн өгүүлэмж бол чоныг Төв Азийн нүүдэлчин олон угсаатантай ч биш, тэр ч атугай нийт Монгол угсаатантай ч биш, харин зөвхөн нэг л ястантай буюу Халхчууд болон түүний язгуур эзэд Хияд яст Боржигин овогтой уялдуулан холбож өгөх чухал баримт заалт болохоос гадна Хүннү болон Монгол хоёр угсаатны угсаа гарлын хэлхээ холбооны мөн чанарыг тодруулах ноцтой гэрч мэдээ болж байгаа юм.

Гэхдээ, Монголын эзэн хаадын Хияд яст Боржигин овгийнхны чоныг язгуур өвөг хэмээн шүтэн биширч байсан асуудлыг ийнхүү хэт шулуухан хөндөн тавьбал бас учир дутагдалтай болно. Учир нь, бидний эш татсан сурвалж бичгийн болон угсаатны зүйн судалгааны мэдээ баримт нь Монгол угсаатан дотроо зөвхөн нэг л тодорхой овог ясны тотемийн өвөг дээдэс байсан уу? Хэрвээ тотемийн өвөг дээдэс байсан бол тэр чоно нь чухам гэндү чоно байсан юм уу?, аль эсхүл өлөгчин чоно байсан юм уу? зэрэг асуултанд ганц утга бүхий тодорхой хариулт өгч чадахгүй болох нь илэрхий байна.

Харин Хияд ястай Боржигин овгийнхон ясан төрлөөр буюу эцгийн талаар удам угсаагаа хөөн хэлэлцэдэг бөгөөд тэдний язгуур тотем гэгдэх амьтан бол гэндүү буюу эр чоно байсныг Хоа Маралын эр Бөртэ Чино болон түүний найм дахь үеийн үр хойчис буюу Бодончар мунхагийн элэнц Боржигидай мэргэн, мөн Боржигин гэдэг овгийн нэр зэрэг эдгээр дам мэдээ сэлт нь битүүхэндээ зааж байна гэж бодном. Энэ дашрамд тэмдэглэхэд, зарим эрдэмтэд “Монголын нууц товчоон”-ы 63-р зүйлд тэмдэглэгдсэн баримт мэдээг үндэс болгон Хияд ястай Боржигин овог нь цагаан шонхорыг өвөг дээдэс мэтээр тотемчилон шүтдэг байсан гэсэн таамаглал дэвшүүлсэн байна (Сүхбаатар, 1980: 75).

Бидний санахад, энэхүү эдрээтэй асуудлын учир шалтгааныг зөвөөр ухааран нягтлахын тулд сурвалж бичгүүд болон судалгааны хүрээнд Алан Гоа эхийн гэж алдаршсан домгийг авч үзэх хэрэгтэй юм.

Харин энэ дашрамд тэмдэглэхэд, бид дундад зууны Монголчуудын язгуурын эзэн хаадын тэнгэрээс буюу нарнаас уг гарвальтайг заасан Алан Гоа эхийн домгийн үзэл санааны үүсэн бүрэлдсэн тухай асуудлыг нягтлан судлах явцдаа тэрхүү үзэл санаа нь өнө эртний домогзүйн сэтгэлгээний тотем төсөөллөөс улбаалан хадгалагдсаныг цохон тэмдэглэж байсан билээ (Мэнэс, 1987: 12-15).

Гэхдээ, биднээс өмнө Буриадын эрдэмтэн Т.М. Михайлов Алан Гоа эхийн домгийн монгол болон түрэг хувилбаруудыг харьцуулан үзэхээс гадна Монголчуудын чоныг “хээрийн нохой”, ”хангай” гэхчлэн нэр цээрлэн нэрлэх тухай мэдээ болон монголын түүхэн сурвалж бичиг дэх Бөртэ чоныг авлаж алахыг хориглосон тухай мэдээ, бас чонос гэдэг овгийн нэр зэргийн баргимтыг үндэслэн, “Монголын нууц товчоон”-д тотеми шүтлэгийн улбаа мөр хадгалагдан үлдсэн тухай бичсэн юм (Михайлов, 1980: 65). Тэрчлэн, Г.Р. Галданова, Д.Д. Нимаев, С. Дулам, П.Б. Коновалов нарын судлаачид өөрсдийн бүтээлдээ чоныг эрхэмлэн шүтэх нь тотемийн утга агуулгатай болохыг цухас тэмдэглэсэн байна (Галданова, 1987: 36; Нимаев, 1988: 82-86; Дулам, 1989: 35; Коновалов, 1990: 55).

Мөн өнөө хэр маргаантай, санал зөрөлдөөнтэй байгаа буюу түүхчдийн аль болохоор тойрч орхиж ирсэн Монгол хаадын Алтан ургийн уг язгуурын тухай асуудлыг Монголын эрдэмтэн У. Эрдэнбат задлан тайлбарлахдаа, Алан Гоа эхийн домгийн утга учрын тухай эрдэмтдийн саналыг нягтлан үзээд эл домгийг уран зохиол болон домогзүйн судалгааны байр сууринаас биш, харин Монголын түүхийн итгэлтэй сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэж үлдсэн бодитой түүхэн үйл явдал болохын нь хувьд түүхийн судалгааны арга зүйгээр судлах шаардлагатай гэж тэмдэглэсэн байна. Тэрчлэн, Монгол хаадын Алтан ургийн угийг мөшгин шинжлэхдээ, Боржигин овгийн язгуур, Монголчуудын хари шири боллох ёс, асрахуй ёс, Монгол хаадын ураг барилдах ёсонд тэнгэр язгуурт хан цагаан ястай хүн харц ардтай ураг барилдахын цээр гэсэн дөрвөн зүйл асуудлыг юуны түрүүнд оновчтой тайлбарласны үндсэн дээр сая Алан Гоа эхийн домгийн “цэгээн шар хүн”,

“шар нохой” гэсэн хоёр хэллэгийг бэрийн бэрлэхүй ёсон дахь чоны нэрийг нэрлэх цээртэй холбон утга учрын талаас задлан нягталжээ. Түүнчлэн, Чингис эзний элэнц дээдэс Бодончар Мунхагийн нэр нь зарим судлаачдын үздэгчлэн эцэггүй хүүхэд гэсэн утгатай Бутанцар гэсэн нэр биш, харин удам угсааны хувьд Малиг Баяудай зарцын хүүхэд бус, Бөртэ Чинуа хааны удам судар, Боржигин овогтны хууль ёсны эзэн байжээ гэсэн дүгнэлтэд хүрсэн байна (Эрдэнэбат, 1997).

Энэхүү Алтан ургийн Добу мэргэний бэлбэсэн хатан Алан Гоа эр нөхөргүй явах атлаа Буха Хатаги, Бухату Салжи, Бодончар мунхаг нэрт гурван хөвгүүнийг төрүүлсэн тухай өгүүлэмж нь цагийн саалтар домог болон хувирсан Алтан ургийн уг удмын түүхийн нэгэн үеийн үйл явдал нь Монголын түүхийн холбогдолтой сурвалж бичгүүд дотроос анх түрүүн “Монголын нууц товчоон”-д тэмдэглэгдэн орсонгоос хойш хожмын ихэнхи сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсээр иржээ.

Алан Гоа эхийн домгийн хамгийн эртний хувилбар нь “Монголын нууц товчоон”-ы 17-21-р зүйлүүдэд буй бөгөөд тэнд: “Тэгэж байтал Добун мэргэн үгүй болов. Добун мэргэнийг үгүй болсны хойно Алангоо бэлэвсэн бөгөөтөл гурван хөвүүн төрүүлэв. [Тэд] Бугу Хатаги, Бугуту Салжи, Бодончар Мунхаг нэртэй бөлгөө.

Урьд Добу мэргэнээс төрсөн Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хөвүүд нь эх юүгээ Алангоог далдуур өгүүлрүүн: “Энэ эх, бидний ах үеэлд хаяалд хүн үгүй, эр үгүй бөгөөтөл эд гурван хөвүүдийг төрүүлэв. Гэр дотор гагц Маалиг баягуудай хүмүүн буй. Эд гурван хөвүүд түүнийх буй за” хэмээн эх юүгээ эчнээ хэлэлцэхийг Алангоо эх нь ухаж [мэдээд] хаврын нэгэн өдөр хонины борц чанаж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буга Хатаги, Бугуту Салжи, Бодончар Мунхаг энэ таван хөвүүдээ зэрэгцүүлэн суулгаж нижгээд сумыг “хугалагтун” гэж өгөв. Ганц [сумыг] амархан хугачиж орхив. Бас таван сумыг хамт боож “хугалагтун” гэж өгөв. Тавуул, таваар [багцлан] боосон сумыг хүн хүн авч тойруулж [оролдоод] хугалан ядав. Тэрэнд Алангоо эх өгүүлрүүн: ”Бэлгүнүтэй, Бүгүнүтэй та хоёр хөвүүд минь намайг энэ гурван хүүхдийг төрүүлэв. Хэний юун хөвүүд вэ хэмээн сэрдэн хэлэлцэв. Сэрдэх чинь зөв. Шөнө бүр цэгээн шар хүн, гэрийн өрх, тотгын гэгээгээр орж [ирээд] хэвлийг минь илбэж гэгээ [гэрэл] нь хэвлийд минь шингэх бөлгөө. Гарахдаа [тэр] наран сарны завсраар шар нохой мэт шазвалзан гарах бөлгөө. Та нар дэмий яахан өгүүлнэ. Тэр тэмдгээр үзвэл тэнгэрийн хөвүүд буюу за

Хар тэргүүт хүнтэй

Ханисган (ижилсэгэн) яахан өгүүлнэ та нар

Хамгийн хаад болбоос харцас тэнд мэднэ” хэмээв” [“17. teyin atala dobun-mergen ügei bolba dobun-mergen-i ügei boluqsan-u qoyina alan-qo'a ere üge<i>'üi bö'et qurban kö'üt töre'ülbi buqu-qadagi buqatu-salji bodoncar-mungqaq nereten büle'e

18. urida dobun-mergen-ece töreksen belgünütei bügünutei qoyar kö'üt inu eke-yü'en alan-qo'a-yin ecine ügüleldürün ene eke bidan-u aqa de'ü üye qaya gü'ün ügei ere üge<i>'yi bö'etele ede qurban kö'üt töre'ülbi ger dotora qaqca ma'aliq-baya'udai gü'ün buyu ede qurban kö'üt te'ün-ü'ei bui-je ke'en eke-yü'en ecine keleldüküi-yi eke anu alan-qo'a uqaju

19. qabur niken üdür köngsilemel qonin cinaju belgünütei bügünütei buqu-qatagi buqatu-salji bodoncar-mungqaq ede tabun kö'üd-iyen jergelen sa'üju niji'el müsüt ququlutqun ke'ejü ökba niji'el-i ya'u bayi'ulqun ququciyu o'orba basa tabun müsüt gü'üleldün bariju bitü'üljü ququlun yadaba

20. *tende alan-qo'a eke inu ügülebi ta belgünütei bügünütei qoyar kö'üt minu namayi ede qurban kö'üd-i töre'ülbi ken-ü ya'un-u kö'üt buy ke'en sereldün keleldümüi sereküi ber tanu jöb*

21. *sönit büri ceügen sira gü'ün ger-ün erüge dotoqa-yin gegē-'er oroju ke'eli minu bilijü gege'en inu ke'eli-tür minu singgegü büle'e qarurun naran sara-yin kili-yer sira noqai metü sicabaljaju qarqu büle'e deleme yekin ügület ta tewüber uqa'asu temdek inu tenggiri-yin kö'üt buyu-je qara teri'ütü gü'ün-tür qanilqan yekin ügület ta qamuq-un qat bolu'asu qaracus tende uqat-je ke'ebe"]* (Монголын..., 2000: Igor de Rachewiltz, 1972).

Өгүүлэмж болон тэдгээрийн хоорондын утга учрын хэлхээ холбоог арай бүрэн хадгалж ирсэн энэхүү эртний хувилбараас гадна бас товч хувилбарууд хэд буй. Тухайлбал, Армяны түүхч Киракос Гандзакецийн тэмдэглэн авсан домогт ийн өгүүлжээ: “Ер нь, тэд ийм юм ярьдаг билээ. Тэдний эзэн бол тэнгэрийг өөрийн хувьд авч, газар дэлхийг хаанд өгсөн тэнгэр бурханы садан төрөл гэнэ. Хааны эцэг Чингис-хан эр хүний үрээс гараагүй юм шиг ярьж байсан ба оргүйгээс нэгэн гэрэл зүгээр л гарч ирээд гэрийн өрхөөр нэвтрэн орж [Чингисийн] эхэд: “Чи үр олж газар дэлхийн эзэн болох хүүг төрүүлнэ” гэж хэлсэн байна. Тэрбээр ийнхүү төрсөн гэж ярьдаг юм. Энэ домгийг бидэнд мамиконян овог удамтай, Марзапаны ах, Асланбег, Саргис, Амир нарын ах ишхан Григор ярьж өгсөн бөгөөд тэрбээр өөрөө тэр домгийг яагаад ч юм залуучуудад сүээр үг заан хэлж байсан Хутун-ноин гэгч татаруудын тэргүүн сурвалжтаны язгууртан нэгэн хүнээс сонссон байна” [“Но обычно они рассказывают вот что: государь их – родственник бога, взявшего себе в удел небо и отдавшего землю хакану. Говорили, якобы Чингис-хан, отец хакана, родился не от семени мужчины, а просто из невидимости появился свет и, проникнув через отверстие в кровле дома, сказал матери [Чингиса]: “Ты зачнешь и родишь сына, владыку земли”. Говорят, так он и родился. Эту [легенду] рассказал нам шихан Григор, сын Марзапана, брат Асланбега, Саргиса и Амира рода Мамиконянов, который сам слышал её как-то от одного знатного человека, по имени Хутун-ноин, из [татарской] высшей знати, когда тот поучал молодежь”] (Киракос, 1976: 32).

Армяны энэ хувилбартай холбогдон дараахь хоёр асуулт гарч ирж байна. Нэгд, тус домогт нэр дурьдагдсан Хутун ноён гэгч хэн бэ? Хоёрт, тус хувилбарын он цагийг яаж тогтоох вэ? гэдэг асуулт тавигдаж байна. Нэг дэх асуултанд хариулахын тулд бид Армяны түүхч Григор Акнерци (Аканч)-йн нэгэн тэмдэглэлийг нягтлан үзье. Түүний түүхэн тэмдэглэлд: “Чармаган Чингис ханы Альтанай хатныг дагуулан явж, Кавказад Их Хурилтай хуралдуулж, түүнд 110 гаруй цэргийн жанжин уригдсан бөгөөд тэнд бүх газар нутгийг өөр хоорондоо хуваан авахыг шийдсэн байна” гэсэн сонирхолтой баримт мэдээ хадгалагдан үлджээ (Grigor, 1954: 204). Мөн Армяны түүхч Кавказад нутаглан суух болсон жанжнуудын нэрсийг тэмдэглэсэн нь бидний сонирхол татаж байна. Энэ тэмдэглэлд: “Асутунуин, Чагатай, Бачу, Хутунуин, Асарнуин, Тутунуин, Огатауин, Ходжауин, Хурумчиуин, Хунануин, Тенануин, Ангуратуин” гэсэн нэр бүхий ноёдын жагсаалтыг оруулжээ (Grigor, 1954: 304). Эдгээр ноёдын нэрсийн жагсаалтын дотор Хутунуин гэдэг нэр бидний сонирхон бүхий Киракос Гандзакецийн түүх дэх Хутун-ноин мөн бололтой.

Бидний энэ таамаглал хэр үндэстэй болохыг зарим баримт мэдээ тодруулан өгч байна. Армяны түүхч А. Галстян Армян нутгийг Монголчууд эзлэн авсан тухай бичсэн өгүүлэлдээ Армян, Гүрж хоёр улсыг дайлахад оролцсон жанжнуудын нэрсийн заримыг дурьдсан байна. Тэр өгүүлэлд: “[Татарууд] тэдний гол бөгөөд

сурвалжит язгууртнууд эд нар юм. Хууль цаазын эрх мэдлийг атгаж эрүү шүүж байсан Чармагун ноён эн тэргүүнийх бөгөөд агуу их, бүх цэргийн тэргүүн бөгөөд эзэн захирагч хүн юм. Түүнтэй хамт Исрар ноён, Гутун ноён, Тутун ноён бөгөөд мулехидууд тэд алсан цэргийн жанжин Чагатай нар хамт хуралддаг юм” [“Вот главнейшие и знатнейшие из них [татар]: первый и великий, глава и повелитель всех войск, Чармагун-ноин, человек, обладающий судебной властью и судивший. Вместе с ним заседают Исрар-ноин, Гутун-ноин, Тутун-ноин и Чагатай – военачальник, которого убили мулехиды”] гэсэн мэдээ заалтыг Армяны он дарааллын бичгээс эш татсан байна (Галстян, 1977: 174).

Армяны он дарааллын сурвалж бичгүүдэд хадгалагдаж ирсэн Монгол ноёдын нэрсийн энэхүү хоёр жагсаалтыг тулган үзвэл, Асар-нойон бол Исрар ноин, Хутту-нуин бол Гутун-ноин, Туту-нуин бол Тутун-ноин, Чагатай бол Чагатай болох бө эдгээр дөрвөн ноёдын нэрс дуудлагын хувьд өөр хоорондоо тохирч байна. Учир иймд, Армяны он дарааллын бичигт Хутту-нуин буюу Гутун-ноин гэдэг нэртэй өндөр сурвалжит нэг л хүнийг заан тэмдэглэсэн нь эргэлзээгүй болж байна.

Тэрчлэн, энэ хүн чухам хэн болохыг заасан баримт мэдээ бас хадгалагдан үлджээ. Тухайлбал, Ильхан улсын түүхч Рашид ад-Дины зохиолд: “Кингит аймгаас гаралтай байсан Кингитай Кутан ноёны мянган” [“Тысяча Кингитая Кутан-нойона, бывшего из племени кингит”] гэсэн товч боловч нэн чухал утга агуулгатай мэдээ заалт тэмдэглэгдсэн байна (Рашид ад-Дин, 1952: т. 1, кн. 2, 274).

Энэ мэдээ заалтын чухал ач холбогдол нь гэвэл, “Монголын нууц товчоон”-ы 120-р зүйлд Тэмүжинийг дагаж ирж нийлсэн 21 овог аймгийн тэргүүлэгчдийн нэрсийн дотор Олхунууд аймгийн Хингиадай [“Olqunuud-un Kinggiyaday”] гэгч нэртэй нэгэн хүнийг дурьдсан нь мэдээтэй тохирч байгаа юм. Бас тус сурвалж бичгийн 202-р зүйлд эсгий туургат улсыг шударгатаж Их Монгол улсыг нэгтгэн барж Чингис хааны зарлигаар нэрийдсэн ерэн таван мянгадын ноёдын нэрсийн жагсаалт дотор Хингиадай [“Kinggiyaday”] гэгчийг мянганы ноён болгосон тухай сонин мэдээ буй (Монголын..., 2000; Igor de Rachewiltz, 1972).

Бидний эш татсан Армян, Перс болон Монгол сурвалж бичгийн мэдээ зангийг харьцуулан үзвэл, Хутту-нуин буюу Хутун-ноин буюу Кутан-нойон нь Олхунууд аймгийн Кингит овог ястай мянганы ноён байжээ гэсэн дүгнэлт хийж болно.

Харин Армян он дарааллын бичгийн мэдээ заалтын он цагийн тухай гэвэл, Алан Гоа эхийн домгийн сүеэн зааж байсан тэргүүн сурвалжит Кутан ноён бол нэрд гарсан Чормаган жанжны хамт байсан нь чухал сэжүүр мэдээ юм. Учир нь, Чормаган жанжны захирсан Монгол цэрэг нь 1236 онд анх Кавказ руу нэвтрэн орсон тухай мэдээ баримт бидний үед хадгалагдан иржээ. Энэ гэрч баримт бол Армяны түүхч Киракос Гандзакецийн багш, Армяны эрдэмтэн Тауш нутгийн Оганес Ванаканы гарын үсэг бүхий дурсамжийн бичиг юм. Монгол цэрэг 1236 онд Арменид цөмрөн ороход Таушийн Оганес Ванакан өөрийн шавь Киракос Гандзакецийн хамт Ариун Оганесийн сүмд амьдарч байсан бөгөөд тэнд нь Монгол цэргүүд олзлон авсан байна. Киракос Гандзакеци зугтаж амжссан байна. Харин Таушин Оганес Ванакан багшийг нь Армянууд барьцааны төлбөрт 80 дакехан өгч Гаг цайзаас гарган авчээ. Оганес Ванаканыг суллах үед Монгол цэргүүдийн булаан авсан Библи судрыг нь эргүүлэн өгчээ. Тэрбээр судар дээрээ дурсамж бичээд, он цаг болон гарын үсгээ бичин үлдээсэн учир Чормаган жанжны захирсан Монгол цэрэг

нь 1236 онд анх Кавказ буюу Армян руу довтлон орсонг лавтайяа зааж өгч буй баримт мэдээ болой (Галстян, 1977: 170).

Иймээс, Армяны түүхч Киракос Гандзакецийн тэмдэглэн авсан Алан Гоа эхийн домгийг Монголчууд, тэр дотроо тэргүүн язгууртнууд ихэд эртдээ гэхэд 1236 онд мэддэг, өөр хоорондоо хэлэлцэн ярилцадаг, бас тэр домгийг залуусад сүеэр үг болгон зааж өгч байжээ гэсэн дүгнэлт хийж болно.

Гэхдээ, Кутан ноён зөвхөн Чормаган ноёны дэргэд байхаас гадна хожим бас Байжу жанжны дэргэд шадарлан байсан байж болно. Энэ учир байдал бол Чормаган жанжин Кавказад болсон нэгэн тулалдаанд чих дүлийрснээс болж түүний оронд Монгол цэргийг Байжу ноён захирах болсон хэрэг явдалтай холбоотой юм. Тэрчлэн, Кавказ болон Умард Иранд байрласан Монгол цэрийн жанжин Байжу ноёны зуны өргөө 1242 оноос 1256 он хүртэл Армян, Азербайжан хоёр нутгийн зааг дээр Сисиан тосгон буюу өнөөгийн Нахичеван хотоос зүүн хойд зүгт байрладаг байжээ. Эдгээр баримт мэдээг түшиглэвэл, Армян сурвалж дахь Алан Гоа эхийн домгийг 1236 оноос 1256 оны хооронд Кавказад нутагласан Монгол язгуурнуудын дунд яригдаж байсан гэсэн дүгнэлт бас хийж болно.

Алан Гоа эхийн домгийн бас нэгэн хувилбарыг Рашид ад-Дины зохиолоос олж үзэж болно. Тэр зохиолд өгүүлсэн ёсоор: “Алан-гоа нөхрөө алдсанаас хойш хэсэг хугацааны дараа гэртээ унтаж байжээ. Тэгтэл гэрийн өрхөөр гэрлийн туяа нэвтрэн орж түүний хэвлийд шингэжээ... Хэсэг үе өнгөрсний дараа тэрбээр хөл хүнд болсноо мэджээ” [“Алан-гоа спустя некоторое время после того, как лишилась мужа, однажды спала дома. И вот через (дымовое) отверстие шатра проник луч света и погрузился в её чрево... Спустя некоторое время она поняла, что забеременела”] (Рашид ад-Дин, 1952: кн. 2, 14).

Харин нэлээн хожуу үед энэхүү домгийг Түвэдийн сударч Гунгаадорж арай өөрөөр ухааран ойлгосон нь бас сонирхолтой юм. Түүний зохиолд: “Добун мэргэнийг үгүй болсон хойно Алан гоа наран саран хоёрын гэрлээс Бодончар мунхагийг төрүүлсэн” гэж бичсэн байна (Бира, 1978: 23).

Ер нь, нар сарны гэрлээс олсон үр хүүхэд дээр тэнгэрээс гаралтай байдаг тухай үзэл нийт Монгол угсаатны дунд ихээхэн түгээмэл байхаас гадна эгэл жирийн хүмүүсийн дунд өргөн хэлэлцэгддэг байсан бололтой. Тухайлбал, Чингис хааны тухай буриадын нэгэн домогт энэ үзэл хэрхэн илэрч буйг өгүүлбэл ийн буюу: “Эртээ дээр үед энэ хорвоод Ухер-Буксе хан (“Үхэр Бөгс хан”) гэгч нэгэн амьдарч байжээ. Ухер-Буксе хан нь ганц охинтой байсан ажээ. Тэр охин хэзээ ч нарны гэрэл үзээгүй бөгөөд ястай мах идэж байгаагүй гэнэ. Нэгэн удаа хоол идэх үеэр тэр охинд шаант чөмөг өгсөн гэнэ. Тэгтэл, охин үүнд ихэд уурлан шаант чөмгийг аваад гэрийн хана руу шийдсэн байна. Шидсэн шаант нь ханаа цолон гарсанд гэр дотор нарны гэрэл гэгээ тусан орж тэр шалтгаанаар Ухер-Буксе ханы охин жирэмсэн болж гэнэ” [“:Давным давно на свете жил Ухер-Буксе-хан. У хана Ухер-Буксе была единственная дочь, которая никогда не видела солнечного света и не ела мяса с костями. Раз к обеду подали ей верхний кончик берцовой кости. Дочь, рассердившись на это, взяла кость и кинула в стену. Кость пробила стену, в юрту проник свет, и дочь Ухер-Буксе от этого сделалась беременною”] (Балдунников, 1926: 76).

Нарны гэрлээс үр олох ийм өгүүлэмж бас “Нарн Герл хаана куукнэ тууж” гэдэг Халимаг ардын үлгэрт гарах бөгөөд тэр үлгэрт өгүүлсэн ёсоор гол баатар нь

хааны охин До Герлийн цээж рүү нарны гэрэл тусгаснаас тэр охин давхар биетэй болсон ажээ (Хальмг..., 1974: т. IV, 153).

Бидний сонирхож бүхий Алан Гоа, Бодончар нарын амьдарч байсан нэгэн үеийн хүмүүс, тухайлбал, X-XII зууны үед Төв Азийн нүүдэлчдийн дундаас хүчирхэг мандаж явсан Монгол угсааны Хятанчуудын төр улсыг үндэслэн байгуулагч Елюй Амбагянийг мөн л ер бусийн байдлаар төрсөн гэж хэлэлцэдэг байжээ. Энэхүү Хятан домгийн өгүүлэмж ёсоор, Елюй Амбагяний эх жирэмсэн болохын өмнө түүний өвөр цээжэн дээр нар унасан гэж зүүдэлсэн гэдэг (Е Лун-ли, 1979: 346).

Хятан улсын эзний тэнгэрлэг гарлын тухай домгийн өгүүлэмжтэй Сяньбичуудын ер бусын хүн төрөх бэлгэдэлт төсөөлөл тун адилхан байгаа нь Хятан, Сяньбичуудын хоёр домог нь соёлын нэг уламжлалаас эх үүсвэртэй буюу Хятан, Сяньби хоёр нэг язгуур гарвалтай учир Сяньбичуудын домог нь Хятанчуудад уламжлагдан үлдсэн ч байж болох юм. Сяньби домгийн хувилбарт өгүүлсэн ёсоор: “Өмнөд Янь (мэ 398-410) улсыг үндэслэгч Сяньби гаралтай Мужун Дэ гэгч эзний эцэг Мужун Хуа гэгч хүн: “Хэрвээ жирэмсэн эмэгтэй хүн түүний цээж рүү нар орсон гэж зүүдэлсэн бол тэрбээр заавал тэнгэрийн хүү төрүүлнэ” гэж ордны шивэгчин нарт байнга ярьдаг байжээ (Материалы..., 1989: 166).

Бидний сонирхон бүхий Алан Гоа эхийн домгийн улбаа мөрийг мөшгөн хөөвөл Хятан, Сяньбичуудаас өмнө төр улсаа байгуулж байсан Хүннү нарын соёлын ертөнцтэй холбогдож байна. Тухайлбал, бидний сэдэвт Хүннү гүрнийг шударгатаан байгуулсан Маодун шаньюйн үр хойчис бөгөөд мэ 304 онд байгуулагдаад 329 онд Хожуу Чжао улсад дайлагдсан Хүннүгийн гурван улсын нэг Бэй буюу Умард Хань улсыг үндэслэгч Лю Юаньхай эзний чухам ямар бэлгэдэлт ёроор төрсөн тухай домог чухал ач холбогдолтой болж байгаа юм. Сурвалж бичигт тэмдэглэсэн ёсоор: “Вэй улсын үед Цзя-пины төр барих цагт (мэ 249-254) Лю Бао гэгчийн язгуурын Хуянь [ястай] гэргий нь Лунмынд хүү соёрхон хайрлахыг залбиран гуйж тахил өргөж байжээ. Тэгтэл, гэнэт толгой дээрээ хоёр эвэртэй том загас гараад ирж гэнэ. Тэр загас сэрвээгээрээ сэлүүрдэж, хайрсаа хөдөлгөсөөр тахилын газар сэлж ирээд ихээхэн удсаны дараа сэлээд явжээ. Болсон явдал бүх илбэч, бөө нарын гайхлыг төрүүлсэн ба тэд: “Энэ бол ивээлт зөн бэлгэт ёр юм” гэж хэлсэн байна. Тэр шөнөдөө язгуурын Хуянь [яст] нь өглөөний харсан загас нь ер бусын гэрэл гэгээ цацруулсан тахианы өндөгний тал хэмжээтэй нэгэн зүйлийг гартаа барьсан хүн болон хувирсан гэж зүүдэлсэн ажээ. Тэр [хүн]: “Энэ бол нарны гол цөм юм. Үүнийг хүлээн авбал алдарт хүү төрүүлэх болно” гэж хэлээд тэр зүйлээ түүнд гардуулжээ. [Язгуурын Хуянь яст] сэрэнгүүтээ ирээдүйн Бэй Хань улсыг үндэслэгчийн эцэг Лю Банд зүүдээ ярьж гэнэ. Лю Бан хариуд нь: “Энэ бол азтай бэлгэ тэмдэг байна. Дээхэн би Ханьданы дүүргийн уугуул Чжан Цюны эх болох язгуурын Сыту ястанд мэрэглүүлсэн бөгөөд тэрбээр: “Чамд заавал гурван үедээ мандан цэцэглэх алдар нэр хүнд бүхий хөвүүд болон ач нар төрөх ёстой” гэж хэлсэн юм. Тэр мэрэг төлөг зүүдтэй таарч байгаа бололтой” гэж хэлжээ. Түүнээс хойш арван гурван сарын дараа Лю Юаньхай мэндэлсэн билээ” [“При династии Вэй, в эру правления цзя-пин (249-254) жена Лю Бао, урожденная Хуянь, совершала жертвоприношение в Лунмыне, молясь о даровании сына. Неожиданно появилась большая рыба, на голове которой было два рога. Двигая плавниками и шевеля чешуей, рыба подплыла к месту жертвоприношения и уплыла только по проишествии длительного времени. Происшедшее удивило всех колдунов и шаманов, которые сказали: “Это благовещее знамение”. В ту же ночь урожденной Хуянь приснилось, что рыба, которую она

видела утром, превратилась в человека, державшего в левой руке предмет размером с половину куриного яйца, испускавшего необыкновенный свет; [человек] вручил ей [этот предмет] со словами “Это сердцевина солнца, примешь её — родишь знатного сына”. Проснувшись, [урожденная Хуянь] рассказала сон Лю Бану, отцу будущего основателя династии Бэй-Хань. Лю Бан ответил: “Это счастливое предзнаменование. Некогда я гадал у урожденной Сыту, матери Чжан Цюна, уроженца округа Ханьдань, и она сказала: “У тебя должны родиться знатные дети и внуки, которые обязательно будут процветать в трех поколениях”. Похоже, что гадание совпадает со сном. Через тринадцать месяцев после этого родился Лю Юаньхай”] (Материалы..., 1989: 31-32).


Ер нь, Хүннүчүүд нар сарыг ихэд бишрэн шүтэж байсан тухай өөр мэдээ баримт бас буй. Тухайлбал, Хүннү гүрний эзэн болох шаньюйг “Газар тэнгэрээс төрсөн, нар сараар өргөмжлөгдсөн” [“Рожденный небом и землей, поставленный солнцем и луной”] гэж дээдлэн хүндэтгэж байжээ (Бичурин, 1960: ч. 1, 54, 58). Түүнчлэн, шаньюй өглөө мандах наранд мөргөдөг бол орой бас саранд мөргөдөг байсан тухай мэдээг дурьдахад сонин буюу.

Хүннүчүүд нар сар хоёрыг ийнхүү онцгойлон сүсэглэж биширч ирснийг зааж харуулсан ноцтой баримт бол тэдний оршуулгын нэгэн зан үйл юм. Тухайлбал, Монголын ахмад археологич Ц. Доржсүрэн аругай Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод гэдэг газрын 12-р булшны модон хашлаганы хойд буюу хүний толгой талын ханын дотор талд дүгрэг бас тал дүгрэг хэлбэртэй хоёр нимгэн алтан чимгийг нарийхан дөрвөлжин хадаасаар хадсан байсныг тэмдэглээд Ю.Д.Талько-Грынцевич Ильмовая падь гэдэг аман дахь 33-р булшаас нар сарны дүрс бүхий чимэглэл олдсоныг эш татжээ (Доржсүрэн, 2003: 113). Сүүлийн үеийн археологийн малтлагын явцад Булган аймгийн Хишиг Өндөр сумын нутаг дахь Бурхан толгойн 8-р булшаас хүрэл сар, 33-р булшаас төмөр нар сарны дүрстэй олдвор гарсан байна (Төрбат, 2000: 57, 67, 183, 204) (**Зураг 2**). Мөн Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод гэдэг газрын 20-р булшнаас илрүүлсэн авсны хүний толгой талын модон хашлагын гадна талд сарны дүрс бүхий нимгэн алтан чимэг хадсан байжээ (Ерөөл-Эрдэнэ ., бусад., 2006: 9, 16), (**Зураг 3**).

Сүүлийн олдвороос дурьдахад, Ховд аймгийн Манхан сумын нутагт, Тахилтын завсар гэдэг газар малтсан Хүнүгийн үед холбогдох 64-р булшаас алтан нар, хавирган сарны дүрс бүхий чимэглэл олдсон байна (Field..., 2007, 5) (**Зураг 4**).

Ийнхүү бид Алан Гоа эхийн домгийн Армян, Перс, Түвэд түүхэн сурвалжууд хийгээд хожмын Монголчуудын үлгэр домогт тусгалаа олсон хувилбаруудад тус домгийн гол зангилаа өгүүлэмж болох “цэгээн шар хүн, гэрийн өрх, тотгын гэгээгээр орж [ирээд] хэвлийг минь илбэж гэгээ [гэрэл] нь хэвлийд минь шингэх бөлгөө. Гарахдаа [тэр] наран сарны завсраар...” гэсэн хэсэг нь ихээхэн товчлогдсон нь илт харагдаж байна. Өөрөөр хэлбэл, уламжлалт сэтгэлгээтэй хуучин цагийн түүхчид болон ер хүмүүс Алан Гоа эхийн Буха Хатаги, Бухату Салжи, Бодончар Мунхаг гурван хөвүүдийн тэнгэр язгуурыг ямагт наран сарны гэрэлтэй холбон үзэж бүрэн итгэж байсан бололтой. Иймээс, Монголын хаадын Алтан ургийнхныг нар сарны гэрлээс олсон, тиймээс тэнгэр язгуурт хэмээгдэх болсон хөвүүдээс удам угсаатай гэсэн шүтлэг бишрэлийн чанартай үзэл баримтлал нь дөнгөж X зууны орчим Алан Гоа эхтэй холбогдон анх үүсээгүй, харин Монголчуудын өвөг дээдээс болох Хятан, Сяньби, хожмын Хүннү төрийн уламжлалтай жижиг улсууд болон Хүннү гүр улсын эздийн тэнгэр гарлын тухай домог яриа, цол хэргэмийн өргөмжлөл

нэрийн утга учир болон археологийн мэдээ баримтыг түшиглэвэл, энэхүү наран сарны тухай төсөөлөл нь Хүннүгийн шаньюй нарын үеэс Чингис хаан хүртэл хөөн үзвэл, барагцаалбал 1500 жилийн түүхтэй болж байна. Учир иймд, Хияд ястай Боржигин овогт эзэн Чингис хааны Алтан ургийн тэнгэр гарлын тухай үзэл нь Хүннүгийн шаньюй нарын тэнгэр гарлын тухай шүтлэг бишрэлтэй холбогдож байгаа нь ердийн тохиолдол биш бололтой гэж бид санаж байна.



Зураг 2.



Зураг 3



Зураг 4

Харин бидний сонирхон бүхий сэдэвтэй холбогдуулан тэмдэглэхэд, наран саран хоёр үр хүүхэд заяадаг тухай төсөөлөл нь Монголчуудын дунд их л сүүл үе хүртэл хадгалагдаж байсан байна. Нар сарыг эрхэмлэн шүтэж байсныг Монголчуудын хуримын зан үйлийн зарим хэсэгт тусгалаа олон хадгалагджээ. Тухайлбал, хурим хийж байх үед гэрбүл болж буй хоёрын залуугийн нь ард нарны дүрс, хүүхнийх нь ард сарны дүрс хадах буюу эсхүл цагаан эсгий дэвсгэр дээр будаагаар баруун талд нь нар, зүүн талд нь сарыг дүрслэн тавьж, нарны дүрсэн дээр эрэгтэй нь, сарны дүрсэн дээр эмэгтэй нь сууж, “шар наранд мөргөж, шаант чөмөг атгах” ёслол үйлддэг байжээ (Дулам, 1989: 89; Сампилдэндэв, 1985: 170). Баруун Монгол буюу Торгууд ястны ёс заншлаар, гэр бүл болж буй хосыг ургах нарнаар ёнгоруу хээ ширсэн эсгий ширдэг дээр үрийн будаагаар нарыг дүрслэн цацаж дээр

нь хүргэнийг суулгаж, бадам хээтэй ширдэг дээр сарыг дүрслэн цацаж бэрийг суулгаад:

“Шар наранд мөргөмүү
Шагай чөмгөнд мөргөмүү
Дөрвөн ээж аавын заяа сахиусанд мөргөмүү
Дээд хан хурмастад мөргөмүү” гэж хэлүүлэн мөргүүлдэг байсан ажээ
(БНМАУ-ын..., 1979: 90).

Мөн Буриадын эрдэмтэн Г.Р.Галдановагийн бичсэнээр, нар шүтэх ёсны хадгалагдаж ирсэн улбаа мөрийг мөшгин үзвэл, бидний өвөг дээдсийн санаанд Нар буюу Наран Саран хоёр нь хүн болон амьд амьтныг бүтээсэн Заячийн бэлгэ дүрс нь байжээ. Нар буюу Наран Саран хоёрыг амь заяагч цагаан тэнгэр хэмээн ухааран биширдэг үзэл санаа бол сурвалж бичиг, ард түмний сахин ирсэн зан заншил хийгээд хожмын үеийн “бөөгийн төрөхийг” бэлгэдсэн бөөг зааж өгөх зан үйлийн үед бөө нарын дуудлагад “нара нара гарбалнай” гэсэн хэллэгт ч тусгалаа олсон байна (Галданова, 1981: 6-7).

Эдгээр мэдээ сэлтээс үзвэл, гэр бүл болж буй хосын хүүг нараар, охиныг сараар бэлгэдэн үздэг байжээ. Тэгвэл, “Монголын нууц товчоон”-ы 61-63-р зүйлүүдэд Есүхэй баатар ёсон настай Тэмүжинийг Өэлүн эхийн төрхөм Олхонууд иргэнд хүргэж, нагац нараас охин гуйхаар одох замд Цэгцэр Чихурху хоёрын зуур Хонгирадай Дэй сэцэнтэй золгоход Дэй сэцэн: “ “Есүхэй худ би энэ шөнө [нэгэн] зүүд зүүдлэв. Цагаан шонхор нар, сар хоёрыг атган нисч ирээд миний гар дээр суув. Энэ зүүдээ бусдад өгүүлрүүн: Нар, сарыг [бид] харж, үздэг бөлгөө. [Харин] одоо энэ [зүүдэнд] шонхор шувуу атган авчирч миний гар дээр минь суув. Цагаан [гэрэл] бууваа. Ямар сайн [зүйл] үзүүлэх бол гэсэн нь Есүхэй худ чамайг эл хөвүүнээ дагуулж ирэхийг энэ зүүд минь мэдсэн ажээ. Зүүд мэргэн зүүдлэв. Юун зүүд байх вэ! Танай Хиад иргэний сүлд ирж заасан ажгуу” [“63. Yisúgey quda bi ene sōni jewūdūn jewūdūleb bi caqān singqor naran sara qoyar-i atqun nisjū irejū qar de'ere minu tu'uba ene jewūdūn-niyen gū'ūn-e ügūlerūn naran sara-yi qaraju ūjekden būle'e edō'e ene singqor atquju abciraju qar-tur minu tu'uba caqān bauba yambar ele sayi ūje'ūlūmū ke'ejū yisúgey quda ene jewūdūn minu cimayi ele kō'ū-be'en uduritcu iregūi-e ūjeksen aju'u. Jewūdūn sayin jewūdūleba ya'un jewūdūn aqu ta kiyat irgen-ū sūlder irejū ja'aqaqsan aju'u”] (Монголын..., 2000; Igor de Rachewiltz, 1972) гэж өөрийн зүүдэлсэн зүүдийн тухай ийнхүү өгүүлсэн нь бидний сонирхон бүхий ерөнхий сэдэвт чухлаас чухал санаа өгч байгаа юм. Учир нь, Дэй сэцэн Есүхэй баатартай золгоод: “Есүхэй худ аль хүрэхээр явна?” гэж асуухад, Есүхэй баатар: “Миний хөвүүний нагац Олхонууд иргэнээс охин гуйхаар явж байна” гэж алсын замд мордсон хэрэг зоригоо хэлсэн бөгөөд Дэй сэцэн шөнө зүүдэлсэн зүүдээ хэлэхдээ, түүний зүүд нь Есүхэй худ “нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй” хөвүүнээ дагуулж ирэхийг үзсэн ба тэр зүүдийг Хияд иргэний сүлдэр буюу цагаан шонхороор бэлгэдэн харуулсан өвөг дээдсийн сүнс сүлд зааж өгөхдөө Хияд ястай Боржигин овгийн сурвалжит язгууртан болох Тэмүжин хөвүүний өндөр угсааг нар сараар бэлгэджээ. Ийнхүү Дэй Сэцэн худ ургийн хэргээр явсан Есүхэй баатар, түүний хөвүүн Тэмүжин, мөн Хияд улс иргэний тэнгэр язгуурыг нар сараар бэлгэдэн өгүүлсэн нь өгүүлэмжийн утга агуулгын хувьд XX зууны Монголчуудын хуримын зан үйл дэх нар сар бишрэн шүтэх, Алан Гоа эхийн нар сарны гэрлээр үр олох, Хятан, Сяньби, Хүннү нарын нар зүүдлэн үр олсон тухай домгууд, Хүннү гүрний шаньюй нарын нар сарнаас төрсөн гэх өргөмж цол зэрэг нь угтаа Монгол угсаатан, тэр дотроо түүний Алтан ураг

болсон Хияд яст Боржигин овог бол Хүннү нарын соёлын буюу шүтлэг бишрэлийн өвийг уламжлан авсныг зааж өгч байна.

Иймд, дундад зууны Монголчуудын Алтан ураг Хүннүгийн шаньюйн урагтай чухам ямар утга учрын хэлхээ холбоотой байсныг тодруулахын тулд Алан Гоа эхийн домгийн үзэл санааны гол зүйл болох Монгол хаалын Алтан ургийн язгуурын дээдэс, эрхэм шүтээн тотемийн дүр төрхийг тодруулан мөшгөх нь зүйн хэрэг гэж үзээд тус домгийн хэдэн зүйлийг онцлон гаргалаа.

Нэгд, Алан Гоа эхийн домог дахь “Шөнө бүр цэгээн шар хүн, гэрийн өрх, тотгын гэгээгээр орж [ирээд] хэвлийг минь илбэж гэгээ [гэрэл] нь хэвлийд минь шингэх бөлгөө” гэсэн өгүүлэмжийн утгыг нягтлан үзвэл, Алан Гоа эх гурван хөвүүнээ цэгээн шар хүний гэгээ гэрлээс [“gege'en”] олжээ гэсэн санааг илэрхийлжээ. Учир иймд, тэр гэгээ бол хүний амь амьдралыг тэтгэн амилуулагч гол хүч, эр үүтгэлтэй буюу эцгийн бэлгэ тэмдэгийг дүрсэлхээс гадна бас тэр чанарыг өнгөөр тодруулан өгүүлсэн байна (Мэнэс, 1987: 13).

Хоёрт, бидний сонирхон бүхий домгийн цэгээн шар хүн нь орж ирэхдээ шөнөөр, гарахдаа наран сарны завсраар гардаг гэсэн хоёр хэсгийн утгыг авч үзвэл, тэр хүний гэгээ гэрэл нь чухам юуны гэрэл болох нь тийм ч тодорхой биш байна. Гэхдээ, Буриад болон Халимагийн үлгэрүүдийн нарнаас үр олсон тухай өгүүлэмж нь нэг талаас, нөгөө талаас Хятан, Сяньби, Хүннү нарын эздийн төрөхийн өмнөх нарны гэрэл, нар зэргийг зүүдэлсэн тухай өгүүлэмжүүд Алан Гоа хатны хэвлийд шингэсэн гэгээн гэрэл бол нарны гэрэл байсныг зааж байгаа хэрэг мөн гэлтэй.

Гуравт, Алан Гоа эхий гэрийн өрх тотгын гэгээгээр орж ирж буй хүнийг “цэгээн шар” гэж өнгөөр бэлгэдэн заасан дүрслэл маш сонирхолтой юм. Энэхүү хэллэг болон дүрслэлийн тухай нэлээд оновчтой тайлбар хийсэн судлаач бол С.Дулам юм. Тэрбээр “Монгол домог зүйн дүр” номондоо бичихдээ: “...Монгол домогзүйн олонхи эх бичгүүдэд...нарыг эр үүтгэл, сарыг эм үүтгэл, оддыг тэдний хөвгүүд болгон дүрсэлсэн байна. “Монголын нууц товчоо”-ны Алан Гоагийн домогт шөнө бүр цэгээн шар хүн гэрийн өрх тотгын зайгаар орж хэвлийг минь илбэж гэгээ нь хэвэлд минь шингэх бүлгээ гэхчлэн өгүүлдэг нь хөвгүүдээ нарны гэрлээс үүсэн төрсөн гэдгийг битүүдээ хэлж байгаа хэрэг мөн. Энд нарыг цэгээн шар хүн болгон дүрсэлснээс гадна гэрэл гэгээтэй байдаг нь бүр ч тодорхой хэрэг. Монголчуудын эцэг эх хоёр нь нар сар хэмээн үздэгийн улбаа энд байх шиг санагдана” гэж тэмдэглээд, өөр нэгэн өгүүлэлдээ “цэгээн шар хүн” гэдэг хэллэгийг нарны гэрлийн хүншүүлсэн дүр (антропоморфизм) гэж үзсэн байна (Дулам, 1989: 89; 1990: 62). Тэгээд шар хүний дүр төрхийг дүгнэхдээ: “Өрх тотгын зайгаар орж ирээд хэвлийг нь илбэж, гэгээ нь хэвлийд шингэсэн гэх буюу наран сарны хилээр гарч оддог гэсэн нь ийнхүү нарны хүншүүлсэн дүр гэдгийг харуулж байгаа юм. Өнөөг хүртэл ардын ярианд, хавар болж, өдөр уртсахыг “урт шар хүн ирэх” гэхчлэн амьдчилан хүншүүлж хэлдэг. Байгалийн аливаа үзэгдлийг амьдчилах буюу хүншүүлэх нь домогзүйн сэтгэлгээний үндсэн шинж билээ” гэж бичсэн байна (Дулам, 1990: 62).

Дөрөвт, Цэгээн шар хүн орж ирэхдээ “гэрийн өрх тотгын завсраар” гэж тодотгон заасныг бодвол, гарахдаа бас л өрх тотгын завсраар гарсан байж болох юм. Юутай ч атугай, Алан Гоа эхийн гэрт өрх тотгын завсраар орж ирсэн тухай тодотгол хэсэг бол тэр орж ирээд гарч байгаа хүний язгуур гарлыг дан ганц өнгөөр ч биш, бас ч орон зай, зүг чигээр бэлгэдэн дүрсэлсэн учир дээр тэнгэрээс заяасан угсаатай, дээд ертөнцтэй холбоотой болохыг зааж буй хэрэг юм.

Тавд, нар сарны завсраар гарч байгаа цэгээн шар хүнийг “шар нохой мэт шазвалзан” хөдөлсөнийг заасан нь бас нарийн утга учиртай байж болох боловч юуны түрүүнд шар нохой гэж өнгө зүсээр болон амьтны дүрээр бэлгэдэн хэлсэн нь тийм ч ердийн зүйрлэл биш бололтой, арай л илүү гүн утга агуулгатай байж болохыг тэмдэглэе. Монголын эрдэмтэн У. Эрдэнэбат “шар нохой” гэдэг хэллэгийн тухай судлаачдын саналыг нягтлан үзээд, тус хэллэгийг “нохойтой холбон тайлбарласнаас ... монголчуудын эртний тотем - чонотой холбон тайлбарлах нь илүү үнэмшилтэй болно. Учир нь, монголчууд эртнээс нохой тэжээхдээ голдуу хар, халтар зүсмийн нохойг эрхэмлэж байсан тул аман ярианд нохойг “хар нохой” гэж хэлэхээс өөрөөр зүс ялгаж хэлэх нь ховор байсан юм. Харин нохойг хар, халтараас бусад өнгөөр “шар нохой”, “хөх нохой”, “бор нохой”, “цоохор нохой” гэж зүс ялгаж хэлсэн тохиолдолд энэ нь чонын зерүүлэн цээрлэсэн нэр болж хувирдаг билээ” гэсэн өвөрмөц мэдээг ажиглан тэмдэглэсэн байна (Эрдэнэбат, 1997: 60-61). Өөрөөр хэлбэл, цэгээн шар хүний тэнгэр язгуур, түүний дээд ертөнцөөс бууж ирснийг нар сар, гэрэл болон гэрийн өрх тотгоор бэлгэдэн үзүүлэхийн зэрэгцээ “шар нохой” гэсэн хэллэгийг хэрэглэсэн нь мөн эр үүтгэлтэй буюу эцгийн бэлгэдэл болсон сурвалжит хүний эрхэм шүтээн, нэр нь мартагдсан боловч дүр төрх нь хадгалагдан ирсэн жилийсэн талийсан болсон амьтанг дурьдсан бололтой. Тэгвэл, тэр шар нохой бол тэнгэр язгуурт хүний уг эхийн амьтанг бэлгэдэн үзүүлсэн домгийн сэтгэлгээний нэгэн өвөрмөц дүрслэл болох тэнгэрийн нохой болж таарч байна.

Гэхдээ бид одоо эдгээр таван зүйл мэдээ баримт нь Хияд ястай Боржигин овгийн шүтээн болсон дээдсийн дүр төрхийн талаар чухам ямар мэдээ заалт хадгалж ирснийг тоймлон мэдэхийн тулд Монголчуудын чонын нэр цээрлэн нэрлэх уламжлалыг мөшгин шинжилье. Энэ асуудлыг хөндөн тавихын тулд бид тус бүлэгт зөвхөн чонын нэрийг цээрлэн нэрлэх зан заншилд холбогдох 116 нэрс бүхий жагсаалтыг хавсаргав (Хавсралт 1).

Эдгээр нэрсийг үе үеийн эрдэмтэн судлаачид олон Монголчуудын бараг бүх ястан бүлгээс тэмдэглэн авсанаас үзвэл, чонын энэхүү цээр ёсыг хуучин цагт Монголын аль ч нутагт чандлан сахидаг байсан бөгөөд зөвхөн чонын нэрийг ийнхүү цээрлэн нэрлэж байснаас бодоход эл цээр нь их л эрт үеэс улбаалсан бололтой.

Харин, бид судалгааны өнөөгийн түвшинд ерөнхий сэдэвтээ захирагдсаны үндсэн дээр: 1. Тэнгэрийн нохой; 2. Тэнгрийн нагац; 3. Нохойн нагац; 4. Боохой буюу бооходой; 5. Цагаан нохой; 6. Таабай; 7. Өвгөн; 8. Бөөн цагаан; 9. Ах; 10. Авга зэрэг 10 нэрийг онцлон үзлээ. Эдгээр 116 цээр нэрийг ерөнхийд нь болон бидний ялгасан 10 нэрсийг тусад нь нягтлан ангилж үзэхэд, Монголчуудын угсаа гарлын асуудлыг тодруулж болох зарим урьдчилсан дүгнэлт гарган авч болох мэт.

Нэгд, XIX зууны сүүл үеэс XX сүүл үе хүртэлх хугацаанд тэмдэглэгдэж ирсэн чонын цээр нэрийн тухай энэхүү арвин их хэрэглэгдэхүүнийг гүйлгэн үзвэл, хамгийн эртний цээр нэр болох “шар нохой” гэдэг нэрээс гадна чонын 45 нэрийг “нохой” гэдэг үгээр орлуулан цээрлэсэн байна. Иймээс, Монголчуудын чоныг нэр цээрлэж нэрлэх уламжлалын хүрээнд “чоно” гэхийг цээрлэж тэр амьтантай аль ч талаараа тун төстэй араатан болох нохойн нэрээр орлуулдаг цээр ёс өргөн дэлгэр байсан бололтой.

Хоёрт, “тэнгрийн нохой”, “тэнгрийн нагац”, “цагаан нохой”, “саарал нохой”, “хадны нохой”, “уулын нохой” зэрэг орон зай, нутаг усыг заасан нэрсээс гадна монгол нохойд байдаггүй “цагаан, саарал” гэсэн өнгө зүсийн утгыг бодон үзвэл, эдгээр нэрс нь юутай ч атугай гэрийн тэжээмэл нохойд ерөөсөө ч хамаагүй болж

байна. Тиймээс, “Монголын нууц товчоон”-ы “шар нохой” нь үнэн хэрэгтээ “тэнгэрийн чоно” болж таарч байна. Өөрөөр хэлбэл, Алан Гоа эх Боржигин овгийн бэрийн хувьд дэр нийлүүлсэн Боржигин овгийн нэгэн язгууртан хүнийхээ нэрийг цээрлэж, түүний ихэс дээдэс болох шүтээн амьтны зүс болон нэрээр орлуулан цээрлэн нэрлэжээ гэж бид үзэж байна.

Бид энэхүү санаагаа улам лавшруулан батлахаас гадна тус цээрийн утга агуулгыг аль болох бүрэн ухааж ойлгохын тулд хэдэн жишээг сонирхон үзье. Тухайлбал, Монголын судлаач Ч. Содном хүний нэр цээрлэх ёстой холбогдол бүхий хэдэн өвөрмөц мэдээ занги тэмдэглэсэн байна. Түүний өгүүлэлд: “Рашид-ад-дины өмнөх тэмдэглэл дэх түүхт хүний түүхэн үйл явдлаас уламжлал бүхий цээр нэр нь орчин цагийн монгол хэлний аялгуунд одоо ч гэсэн хадгалагдсаар бөгөөд тухайлбал буриад аялгуунд ”толь”-ийг “гэрэл” нэрлэдэг нь ихэс дээдсийнхээ нэр хүндэтгэн цээрлэх эртний заншлаар Чингисийн хүү Толой хааны нэрийг цээрлэсэн нь буюу” гэсэн сонирхолтой ховор мэдээ дурьдаад, цааш нь ”Адуучийн Нямын бэрээд, Адууч гэхийг цээрлэж адууг агт гэдэг. Орнын Цэвээний бэр орох гэдэг үг цээрлэж орно уу? та гэхийг шургана уу? та гэдэг байсан гэж Дорнод аймгийн Дашбалбар сумын малчин Цэвэгийн Базар гуай ярихад, тиймээ! манай эжий тэгш гэхийг цээрлэдэг байсан тул түүнтэй дуудлага ойрын учир тэвш гэдэг үг хэлдэггүй их таваг гэдэг байсан, бас Намтайн бэрүүд намтай (надтай), чамтай гэдэг үгийг намлаар, чамлаар гэж цээрлэн халтиргаж хэлдэг байсан, мөн Галзуудын бэрээд гал гэхгүй цуцал гэдэг. Шарийн бэрээд шар өнгийг цээрлэж ангир гэдэг байсан юм. Ер нь хуучин цагт эхнэр хүн хадмын долоон үеийг цээрлэдэг байсан юм гэдэгсэн гэж мөн сумын ард 68 настай эмгэн Тэгшийн Пагмаагийн ярьсныг монголчуудын цээрлэн нэрлэдэг заншлын тухай тэмдэглэлд бас нэг жишээ болгоход илүүдэхгүй бизээ” гэж тэмдэглэн бичжээ (Содном, 1964: 62, 63).

Эдгээр аман мэдээ занги нь олон Монголчуудын зүүн нутгийнхны нэр цээрлэх ёсны хэдэн сонирхолтой жишээ юм. Тэгтэл, Баруун Монголчууд буюу тэдний нэг хэсэг болох Захчин ястны хуучин заншил ёсоор бэрүүд хадам эцэг эхийн нэрийг дуудан хэлэхийг хатуу цээрлэхээс гадна бас нөхрийн талын ахмад хүмүүсийн нэрсийн эхний үе буюу язгуур үндэстэй нь дуудлага ойр амьтай амьгүй элдэв юмсын нэрсийг хэлэхийг ихэд цээрлэдэг байжээ. Захчин самгадын хууч яриагаар бол тэдний хадам эцгүүд Цаадай, Чулуун, Галдан, Баяр, Хөх гэдэг нэртэй байсан ажээ. Тиймээс, бид “цай”, “чулуу”, “гал”, “баярлах”, ”хөх” гэдэг үгс хадам эцгүүдийн нэртэй дуудлага ойр байсан учир тэдгээр үгсийг тун их цээрлэж хэлдэггүй байсан. Оронд нь “ундаа”, “хад”, “заль”, “уярах”, “цэнхэр” гэж цээрлэн хэлдэг байсан гэнэ (Мэнэс, 1989: 16). Бас Дөрвөдийн доторх Цоохормууд яс элкэний бэрүүд “цоохор” гэдэг үгийг “эрээн” гэж цээрлэн хэлдэг байсан тухай угсаатан зүйч Ц. Аюушийн тэмдэглэсэн аман мэдээг дурьдахад сонин буюу (Аюуш, 1978: 47).

Ер нь, нэгэнт өгөгдсөн нэрийг цээрлэн нэрлэх ёсыг нийт Монголчуудын ердийн ахуй амьдралд хэр хатуу сахиж байсныг сургамжийн чанартай ардын нэгэн хөөр яриа тов тодорхой өгүүлж байна. “Монгол ардын нэгэн үлгэр домгийн дотор: - Урьд цагт цэцэн бэртэй өвгөн эмгэн хоёр байж гэнэ. Нэг өдөр бэрийнхээ ёс горим хэрхэн сахиж байгааг шалгах дашрамаар цэцэнийг сорьж үзэхээр шийдээд хадам эцэг нь өдөр хонио хариулж явах зуур хуцаа сайрын эхний өнчин ганц хайласнаас уяж орхиод гэрт ирж оройхон тийш ийн хэлжээ. Бэр ээ? Түмэн хонины түрүүнд явдаг түнтгэр халзан хуц маань үзэгдэхгүй байх шиг санагдсан. Энэ сайраа өгсөж, хараад ирээч! гэж гэнэ. Бэр нь эргэн тойрныг ажигласаар хөндий өгсөж явж байтал сайрын эхний хайлаасны ёроолд нэгэн юм бүрэлзэх шиг болж. Хүрч очвол хуцы нь идэж

ханасан чоно цаашаа шогшиж явна гэнэ. Сэг дээр үлдсэн толгойг харвал хуц нь мөн ажээ. Бэр буцаж ирэхэд хадам эцэг нь олов уу? Хаагуур явав? гэж асууж байв гэнэ.

— Юуны тань олох! Урсгалын эхэнд ургаагийн хажууд Майлмайн ах Дардмайг Улимай нь ирээд шамшиж орхиж. Та Дэлдгэрээ унаад сэргэрээ үүрээд явах юм биш үү! гэсэн гэдэг.

Бэрийн хадмуудын дунд Усан, Модон, Хонин, Хуц, Чоно, Илжиг, Нуман гэдэг нэртэй бэрлэх хүмүүс байсан тул тэдгээрийн нэртэй адил уг зүйлсийг урсгал, ургаа, майлмай, дардмай, улимай, дэлдгэр, сэргэр гэдэг үгсээр тус бүрийг цээрлэн нэрлэж хадам эцгийн сорилтыг оновчтой цэцнээр хариулсан тухай өгүүлсэн байдаг“ (Содном, 1964: 61-62).

Энэхүү Монгол эхнэрийн бэрлэх ёсыг нийт Монгол туургатан дунд мөрдөж байсныг П. Аалто, Ч. Содном, Б. Ринчен, Г. Цэрэнханд, Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв, Д. Нансалмаа болон бидний тэмдэглэн авсан цэцэн бэрийн хэд хэдэн хувилбар болон заншил тодорхой зааж байна (Аалто, 1991: 226; Содном, 1964: 63; Ринчен, 1969: 93; Цэрэнханд, 1972: 59-60; Гаадамба, 1977; Сампилдэндэв, 1985; БНМАУ-ын..., 1987: 278; Мэнэс, 1989: 16).

Мөн хуучин цагт шинэ бэр хадмын талынхны хэн хэний нэрийг чухам ямар үгээр эерүүлэн цээрлэх ёстойг зааж хэлдэг байжээ. Энэхүү бэрийн нэр цээрлэх ёсны чухал хэсгийг хуримын үед бэрд хадмын талынхан өөрсдийг нэрийг хойшид ямар үгээр цээрлэн дуудах тухайгаа хэлж өгдөг ажээ (Сампилдэндэв, 1985: 174). Баруун Монголд буюу Захчин ястны хуримын зан үйлд хадам эцэг нь бэрдээ мал амлах ёс гүйцэтгэх үед нэрээ хэлж бэр тэр нэрийг нь хэлэхгүй байх ёстой ба тэрч атугай бэр хадмын нэрийн эхний үсэг орсон үг бүхнийг бас цээрлэх ёстой байжээ (Мэнэс, 1987: 90).

Бидний эшилсэн эдгээр цөөн мэдээ зангийг хураангуйлан үзвэл, хуучин цагт буюу XIX зууны сүүл үеэс XX зууны шувтрага үе хүртэлх харьцангуй богино хугацаанд тэмдэглэгдсэн аман мэдээ нь Монголчуудын бэр бэрлэхүй ёс заншлын дагуу бэрүүд хадам талынхаа ахмад хүмүүсийн нэрийг цээрлэж, дуудлага ойр үгийг халтиргаж хэлэх буюу өөр үгээр эерүүлэн хэлэх ёс журамтайгаас гадна бас тэдний долоон үеийн хүмүүсийн нэр дуудахыг цээрлэж байсныг тодруулан нотлож байна. Тэгвэл, тэртээ олон зуун жилийн өмнө амьдарч байсан Монгол эхнэрүүд буюу тухайлбал, X зууны үед бэр бэрлэх ёсны учир шалтгааныг бүрэн утгаар нь ухааран мэддэг, тэрхүү хэв ёсоо чандлан сахиж ирсэн Монгол бэрүүд, тэр дотроо тэнгэр гаралтай хаадын олон ургийн нэг болох Хияд цагаан ястай, Боржигин овгийн Алтан ургийн сурвалжит хүн Добун мэргэний гэргий, мөн л өндөр язгуурт Хори Түмэдийн ноён Хорилардай мэргэний гэргий холхи газрын Баргужин төхөмийн эзэн Баргудай мэргэний охин Баргужин Гоагаас төрсөн, үнэнхүү гоо сайхан, алдар нэр хүнд, оюун ухаан төгс, цэцэн цэлмэг Алан Гоа нь бэрийн бэрлэхүй ёсыг сайтар мэдэх учиртай хүмүүс тул нөхрийн талын ахмад хүмүүсийн нэр болон тэдний долоон үеийн өвөг дээдсийн нэрийг цээрлэн нэрлэх ёс заншлаа эрхиш мөрдсөн байж таарна.

Хэрвээ учир байдал ийм байсан бол, Алан Гоа хатан Добун мэргэн нөхрөө үгүй болсны хойно төрүүлсэн гурван хөвүүний эцэг болох эрхэм хүнээ хүндэтгэн үзэж, түүнийг нэрийг урьд Добун мэргэнээс гарсан Бэлгүнүтэй, Бүгүнүтэй болон бусад гурван хөвүүд, мөн ойр холын хүмүүст ёрөөсөө ч хэлэлгүй, зөвхөн “шар нохой” гэсэн ёгтлосон утга бүхий үгээр зүйрлэсэн нь угтаа “тэнгрийн нохой”, “тэнгрийн нагац” гэх зэргийн цээр нэр лүгээ адил “шар” гэдэг үгээр тэнгэр язгуурыг бэлгэдэн заасан өнгөөр эерүүлэн цээрлэсэн байхад, “нохой” гэдэг үгийн утгыг

бодвол, Алан Гоатай гэр бүлийн харилцаанд байсан хүний язгуурын өндөр өвөг буюу тотем нь чоно байсан учраас тийнхүү өөр үгээр давхар эерүүлэн хэлжээ гэж бид санаж байна. Алан Гоа эхийн домогт өгүүлж буй “шар нохой” хэмээх хэллэгийн утга учрыг ийнхүү тайлбарлан үндэслэвэл, урьд Монголын эрдэмтэн У. Эрдэнэбатын тэмдэглэснээр: “алан Гоа хатан нөхрийгөө нас барсны дараа, эртний монголчуудын гэр бүлийн “асрахуй” (левират) ёсоор Добун мэргэний төрөл садангийн хэн нэгэн хүнтэй гэр бүлийн харилцаанд орж, гурван хөвгүүн төрүүлсэн тул, урьд Добун мэргэнээс гарсан Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хөвгүүндээ эдгээр хөвгүүд Малиг баяудайн зарц мэт харц хүнтэй адилтгаж болохгүй, өндөр дээд язгууртны удам болохыг ухуулан хэлж, тэр тэнгэр язгуурт хүнээ хадмын алтан ургийн Боржигин овгийн тотеми чонын хүндэтгэн цээрлэсэн нэр “шар нохой”-гоор бэрлэж хэлсэн бололтой” гэсэн дүгнэлт бол маргаангүй зөв юм.

Гуравт, “бооходой” буюу “боохой”, “таабай”, “өвгөн”, “ах” гэсэн цээр нэрсийн утгыг хянан үзвэл, эдгээр нь золгуй явдлаар нас барсан хүний тэнэмэл сүнс (Манжигеев, 1978: 23) буюу аль эсхүл настай хөгшин хүнийг дуудах нэрс байгаа учир бол Монголчуудын чоны нэрийг ийнхүү эерүүлэн дуудах ёс бол угтаа түүнийг бодит хүн гэж ёр төсөөлдөггүй, харин өөрийн тотемийн бүлэг төрөлд багтан явдаг амьд үр хойчистоо эргэн төрж ирдэг балар эрт цагийн нэр ус нь бүрэн мартагдсан талийсан жилийсэн тотемийн өвөг дээдсийн сүнс сүлд мэтээр ухааран төсөөлдөг шүтлэг бишрэлээс улбаатай бололтой (Токарев, 1964: 66, 69).

Дөрөвт, Алун Гоа хатантай гэр бүлийн харилцаанд орсон Боржигин овгийн хэн нэгэн хүний гэрлээс гурван хөвүүн төрсөн бөгөөд тэр хүний нэрийг “шар нохой” гэж нэр цээрлэн дуудаж байгаагаас бодоход, Боржигин овгийн өвөг дээдэс болох эрхэм шүтээн амьтан бол яавч өлөгчин чоно байх үндэсгүй болж байна. Тэгтэл, бас “таабай”, “өвгөн”, “өвгөн”, “авга” зэрэг цээр нэрсийн утгыг мөшгин үзвэл, Монголчуудын, тэр дотроо Боржигины язгуур өвөг амьтан нь өлөгчин чоно биш, харин гэндү чоны дүрээр төсөөлөгдөх нь илүү бууж байна.

Эцэст нь дүгнэхэд, сурвалж бичгийн мэдээ баримт хийгээд угсаатан судлалын эх хэрэглэгдэхүүнийг мөшгин шинжилсэний үндсэн дээр бид олон Монголчуудын дотроос тодорхой нэгэн угсаатны бүлэг буюу Хиян яснаас угшилтай Боржигин овгийнхны эрхэм шүтээн язгуур өвөг буюу тотем нь Гэндү буюу эр чоно байсан тухай нэлээд ноцтой үндэслэл бүхий ойлголттой боллоо. Монгол угсаатны чоно шүтэн бишрэх үзэлд чоноос угсаагаа залган тоолох нь ямагт эцгийн тал буюу ясаа барьж хөөдөг уламжлал нэлээн тод томруун мэдэгдэж байгаа учир Хүннүгийн эзэн шаньюйн урагтай Хияд ястай Монголын хаадын ураг л худ ураг болж ирсэн байж болох нь учир зүйн бүрэн үндэслэлтэй гэж үзэж байна.

Тэрчлэн, Гэндү чоно болон Өлөгчин чоно хоёр нэг төрлийн амьтан боловч домог зүйн сэтгэлгээний хүрээн дэх тотемчилох үзлийн ёсонд амьтны хүйсийн ялгаа чухлаас чухал бэлгэ тэмдэг болж ирсэн учир эртний Түрэг болон Монголчуудын хаадын уг язгуур тэс өөр байсан нь цаашид дахин хэлэлцэж маргахын хэрэг байхгүй гэж санаж байна. Ийм учраас, Хүннү болон Сяньби хоёр улс иргэний зарим сурвалжит ураг овгууд өөр хоорондоо худ ургийн холбоотой байсан бөгөөд тэр хэлхээ холбоо ёс дагуу өвөг Монгол аймгуудын зарим нь эртний Түрэгчүүдийн дотор нэвтрэн орж, улмаар ууссан боловч өөрийн язгуурын нэр хийгээд угсаа гарвалаа мартаагүй тул Чино буюу Хятад галигаар Ашина яс бүрэлдэхэд хүргэсэн тухай Зөвлөлтийн эрдэмтэн Л.Л. Викторовагийн таамаглал нь үндэслэлгүй гэж үзэхэд хүргэж байна (Викторова, 1980: 156).

НОМ ЗҮЙ

- Аалто П.*, 1959. Халимаг бүсгүйчүүлийн хэлний тухай. Олон Улсын Монгол Хэл Бичгийн Эрдэмтний Анхдугаар Их Хурал. Дэвтэр 1, УБ.
- Алтан товч, Лувсанданзан*, 1957. Ц.Шагдар шинэ үсгээр буулгав.
- Аюуш Ц.*, 1978. 1978 онд Увс, Ховд аймагт явуулсан угсаатны зүйн судалгаа (Дөрвөд, баяд, өөлд, захчин, хотон). УБ. ШУА Түүхийн Хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг (цаашид ШУА ГБСХ).
- Балдунников А.*, 1926. Предание о Чингис-хане. Бурятоведческий сборник. Вып. 1. Издание Бурят-Монгольской секции Восточно-Сибирского Отдела Русского Географического общества.
- Бернишам А.Н.*, 1946. Социально-экономический строй орхоно-енисейских тюрок VI-VIII вв. М.-Л.
- Бернишам А.Н.*, 1959. Очерки истории гуннов. Л.
- Бира Ш.*, 1978. Монгольская историография (XIII-XVII вв.). М.
- Бичурин Н.Я.*, 1950. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. Т. I. М.-Л.
- БНМАУ-ын угсаатны зүй*, 1987. Боть 1. Халхын угсаатны зүй. Уламжлалт шүтлэг. УБ.
- Будаев Ц.Б.*, 1975. Лексика бурятских диалектов в сравнительно-историческом освещении. Новосибирск.
- Вандуй Э.*, 1970. Халхын аялгуу, түүний үгсийн сан. Халхын аялгуу. УБ.
- Викторова Л.Л.*, 1980. Монголы. Происхождение народа и истоки культуры. М.
- Вяткина К.В.*, 1960. Монголы Монгольской Народной Республики. Восточно-Азиатский этнографический сборник. Новая серия, т. LX. М.-Л.
- Гаадамба Ш.*, 1977. XVII-XVIII зууны үеийн түүхийн сурвалж бичгийн доторхи уран домог. Монголын уран зохиолын тойм. II дэвтэр. УБ.
- Гаадамба Ш.*, 1989. Утга зохиолын онолын үндэс. УБ.
- Галданова Г.Р.*, 1987. Доламаистские верования бурят. Новосибирск.
- Галстян А.*, 1977. Завоевание Армении монгольскими войсками. Татаро-монголы в Азии и Европе. М.
- Далай Ч.*, 1959. Монголын бөөгийн мөргөлийн товч түүх. *Studia Ethnographica*. Боть 1, дэвтэр 5. УБ.
- Дамдин Ж.*, 1963. Буурал анчны тэмдэглэл. УБ.
- Дисан Т.*, 1984. 1984 онд Халхын зүүн хэсэгт явуулсан угсаатны зүйн судалгааны тайлан. УБ. ШУА ТХ ГБСХ.
- Доржсүрэн Ц.*, 2003. 1956-1957 онуудад Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн нь. Археологийн судалгаа. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл. УБ. 109-125.
- Дугаров Д.С.*, 1983. Орнитозооморфная символика женского костюма некоторых тюрко-монгольских народов. Материальная и духовная культура калмыков. Элиста.
- Дулам С.*, 1989. Монгол домог зүйн дүр. УБ.
- Дулам С.*, 1990. “Монголын Нууц Товчоо”-н дахь зүүд, зөн совингоор бэлгэдэх ёс, уран сайхны дүрслэлийн арга хэрэглүүр болох нь. Шинжлэх Ухааны Академийн Мэдээ. ¹ 2. УБ. 61-74.
- Дулам С.*, 1992. Дархад бөөгийн уламжлал. УБ.
- Ерөөл-Эрдэнэ Ч., Батболд Н., Гантулга Ж.*, 2006. Монгол-Францын хамтарсан хээрийн шинжилгээний ангийн 2005 оны ажлын тайлан. УБ.
- Киракос Гандзакечи*, 1976. История Армении. Перевод с древнеармянского, предисловие и комментарий Л.А. Ханларян. М.
- Коновалов П.Б.*, 1990. Историко-археологическая интерпретация мифа о Буртэ-чино и Гуа-марал “Сокровенного сказания монголов”. *Mongolica*. Vol. 1 (22). УБ.
- Кононов А.Н.*, 1958. Родословная туркмен. Сочинение Абу-л-гази. М.-Л.
- Манжигеев И.А.*, 1978. Бурятские дошаманистические и шаманистические термины. М.
- Материалы по истории древних кочевых народов группы дунху*, 1984. Введение, перевод и комментарии В.С. Таскина. М.

- Материалы по истории кочевых народов в Китае*, 1989. III-V вв. Выпуск 1. Сюнну. Перевод с китайского, предисловие и комментарии В.С. Таскина. М.
- Материалы по истории сюнну (по китайским источникам)*, 1968. Вып.1. Предисловие, перевод и примечания В.С. Таскина. М.
- Материалы по истории сюнну (по китайским источникам)*, 1973. Вып. 2. Предисловие, перевод и примечания В.С. Таскина. М.
- Михайлов Т.М.*, 1980. Из истории бурятского шаманизма (с древнейших времен до XVIII в.). Новосибирск.
- Монголын нууц товчоо*, 2000. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Зохиогч Д. Цэрэнсодном. Редактор, проф. Д. Төмөртоогоо. УБ.
- Мэнэс Г.*, 1986. 1986 онд Ховд аймгийн Манхан сумын захчин нарын дунд явуулсан угсаатны зүйн хээрийн шинжилгээний тайлан. УБ. ШУА ТХ ГБСХ.
- Мэнэс Г.*, 1987. 1987 онд Ховд аймгийн Алтай, Үенч сумдын захчин ясны дунд явуулсан угсаатны зүйн хээрийн шинжилгээний тайлан, аман мэдээ хэрэглэгдэхүүн. УБ. ШУА ТХ ГБСХ.
- Мэнэс Г.*, 1987. О генезисе и эволюции идеи небесного происхождения правящего “золотого” рода средневековых монголов. Этнографийн судлал. Боть 10, дэвтэр 3. УБ.
- Мэнэс Г.*, 1989. 1989 онд Ховдын захчин таван суманд явуулсан угсаатны зүйн хээрийн шинжилгээний тайлан, эх хэрэглэгдэхүүн. УБ. ШУА ТХ ГБСХ.
- Нансалмаа Д.*, 1981. Төв Халхад явуулсан угсаатны зүйн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн. УБ. ШУА ТХ ГБСХ.
- Нимаев Д.Д.*, 1988. Проблемы этногенеза бурят. Новосибирск.
- Очир А., Сэржээ Ж.*, 1983. “Боржигин” нэрийн гарлын тухайд. Түүхийн судлал. Боть 17, дэвтэр 9. УБ.
- Потанин Г.Н.*, 1883. Очерки Северо-Западной Монголии. Вып. 4. Материалы этнографические. СПб.
- Пунсаг А.*, 2003. Монголчуудын уламжлалт цээрийн ёс. УБ.
- Рассадин В.И.*, 1987. Промысловая лексика в говоре окинских бурят. Диалектная лексика в монгольских языках. Улан-Удэ.
- Рашид ад-Дин*, 1952. Сборник летописей. Т. I, кн. первая. Перевод с персидского Л.А.Хетагурова, редакция и примечания проф. А.А.Семенова. М.-Л.
- Рашид ад-Дин*, 1952. Сборник летописей. Т. I, книга вторая. Перевод О.И.Смирновой, прим. Б.И.Панкратова и О.И.Смирновой. М.-Л.
- Рашид ад-Дин*, 1960. Сборник летописей. Т. II, Перевод с персидского Ю.П.Верховского, примечания Ю.П.Верховского и Б.И.Панкратова, редакция проф. И.П.Петрушевского. М.-Л.
- Ринчен Б.*, 1969. Монгол Ард Улсын хамниган аялгуу. УБ.
- Самшилдэндэв Х.*, 1985. Малчин ардын зан үйлийн уламжлал. УБ.
- Содном Ч.*, 1964. Монгол хүний нэрийн тухай. Монголын судлалын зарим асуудал. боть 4, дэвтэр 15. УБ.
- Сумьяабаатар Б.*, 1966. Буриадын угийн бичээс. Түүхийн судлал. Боть 3, дэвтэр 2. УБ.
- Сүхбаатар Г.*, 1971. Сяньби нарын угсаа гарал, соёл, аж ахуй, нийгмийн байгуулал (нэн эртнээс мэ 4-р зуун). УБ.
- Сүхбаатар Г.*, 1980. Монголчуудын эртний өвөг. УБ.
- Сэр-Оджав Н.*, 1987. Баянлигийн хадны зураг. УБ.
- Тангад Д.*, 1979. Торгуудын хээ угалзны учир холбогдлоос. Түүхийн судлал. Боть 14, дэвтэр 8. УБ.
- Токарев С.А.*, 1964. Ранние формы религии. М.
- Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрдэнэбат У.*, 2000. Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд (Хүрлийн үеэс Монголын үе). УБ.
- Хальмг туульс (Калмыкские сказки)*, 1974. Т. IV. Элиста.
- Цолоо Ж.*, 1969. Баруун Халхын аман аялгуу. Халхын аялгуу. УБ.
- Цыдендамбаев Ц.Б.*, 1972. Бурятские исторические хроники и родословные. Улан-Удэ.

- Цэрэнханд Г., 1972. Хөдөө аж ахуйн нэгдэлчдийн өрх гэр, гэр ахуй (Архангай аймгийн Чулуут, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум нэгдлүүдэд явуулсан судалгааны материалаар). Этнографийн судлал. Боть 4, дэвтэр 8. УБ.
- Черемисов К.М., 1973. Бурьяд-Ород словарь. М.
- Эрдэнэбат У., 1997. “Монголын нууц товчооны” Алан гоа эхийн домгийн учир. УБ.
- Galdan, 1960. Erdeni-yin erike kemekü teüke bolai. Monumenta Historica. T. III, fasc. 1. Nasunbaljir keblele-dü beledkebe. Ulaγanbayatur.
- Field report for 2007 excavations: Tahiltin-Hotgor, Mankhan sum, Khovd aimag, 2007.
- Grigor Aknerci, 1954. History of Nation of the Archers by Grigor Akanc. Cambridge.
- Igor de Rachewitz, 1972. The Secret History of the Mongols. Mongqol-un niuca tobca'an. Part I: Text. Bloomington, Indiana.
- Poppe N., 1964. On some mongolian names of wild beasts. Central Asiatic Journal. Vol. IX, № 2.
- Qad-un ündüsün quriyangyui altan tobči (Эх бичгийн судалгаа). Monumenta Mongolica, 2002. Тэргүүн дэвтэр. Tomus II. Transcription and index by Sh.Choimaa. Ulaγanbayatur.
- Sayan sečen. Erdeni-yin tobči. Monumenta Historica, 1961. T. I. Fasc. I. Nasunbaljir keblele-dü beledkebe. Ulaγanbayatur.

ХАВСРАЛТ 1

**МОНГОЛЧУУДЫН УЛАМЖЛАЛТ СОЁЛ ДАХЬ ЧОНЫН НЭРИЙГ
ЦЭЭРЛЭН ДУУДАХ НЭРСИЙН ЖАГСААЛТ**

- | | |
|---------------------|---|
| 1. Киян | (Монголын..., 2000: §§ 63,67) |
| 2. Шар нохой | (Монголын..., 2000: §§ 63, 67; Дулам, 1992: 63; Эрдэнэбат, 1997: 60-73) |
| 3. Урга сүүлтэ | (Потанин, 1883: 157) |
| 4. Ута һүүлтэ | ibid. |
| 5. Муду сүүлт | ibid. |
| 6. Сүүлт | ibid. |
| 7. Гонзогой һүүлтэ | (Потанин, 1883: 197) |
| 8. Боохой | (Далай, 1959: 10) |
| 9. Хээрийн амьтан | ibid. |
| 10. Хангайн амьтан | ibid. |
| 11. Модго | ibid. |
| 12. Бэлтэрэг | (Аалто, 1961: 228) |
| 13. Хүйтэн шинжит | (Дамдин, 1963: 42) |
| 14. Лувсан гэлэн | ibid. 62 |
| 15. Мөлхөө Лувсан | ibid. |
| 16. Ойдов гэцэл | ibid. |
| 17. Хээрийн юм | (Poppe, 1964: 167) |
| 18. Бурханай нохой | ibid. |
| 19. Тэнгрийн нохой | ibid. |
| 20. Цуутай авга | ibid. |
| 21. Хээрийн авга | ibid. |
| 22. Сэгэлдий авга | ibid. |
| 23. Дарма | ibid. |
| 24. Муу ёрт | ibid., 168 |
| 25. Хээрийн муу ёрт | ibid. |
| 26. Шар нүдэт | ibid. |
| 27. Ноосон толгойт | ibid. |
| 28. Гөнжий толгойт | ibid. |
| 29. Саарин хамарт | ibid. |
| 30. Жирэнхэй | ibid. |

- | | |
|----------------------------|---------------------------|
| 31. Зарагар | ibid. |
| 32. Зараа | ibid. |
| 33. Гозгор чихт | ibid. |
| 34. Шируун | ibid. |
| 35. Арзагар шүдэн | ibid. |
| 36. Гарюухан | ibid. |
| 37. Хүйтэн шэнжэтэ | ibid. |
| 38. Хүйтэн шируун | ibid. |
| 39. Напшагта | ibid. |
| 40. Цоохор нохой | (Сумьяабаатар, 1966: 225) |
| 41. Бор нохой | ibid., 226 |
| 42. Хөдөөний нохой | (Цолоо, 1969: 2134) |
| 43. Жимба | ibid. |
| 44. Номхон увш | ibid. |
| 45. Хөдөөгийн цагаан нохой | ibid. |
| 46. Өнөөх жийхгар | (Вяткина, 1969: 171) |
| 47. Зоохой | (Вандуй, 1970: 99) |
| 48. Зоодгой | ibid. |
| 49. Мөлхөө бор | ibid., 104 |
| 50. Өвгөн | (Сүхбаатар, 1971: 51) |
| 51. Улимай | (Содном, 1964: 61) |
| 52. Ах | ibid. |
| 53. Ясан нүдэн янгарваа | (Цэрэнханд, 1972: 60) |
| 54. Бүртэ | (Черемисов, 1973: 124) |
| 55. Хээрийн хүхэ | ibid., 729 |
| 56. Хаахалдай | ibid. |
| 57. Номгоодоз уваша | (Будаев, 1975: 52) |
| 58. Хангайн нохой | (Нансалмаа, 1981: 20) |
| 59. Бөрт хайрхан | (Очир, 1983: 100) |
| 60. Чанданы эзэн | ibid. |
| 61. Хэвтээ Самбуу | (Дисан, 1984: 4) |
| 62. Боохолдой | (Мэнэс, 1986: 50) |
| 63. Үхээнц | ibid. |
| 64. Хүдөгэй таабай | (Галданова, 1987: 36) |
| 65. Хангайн таабай | ibid. |
| 66. Хүдөөгэй убгэн | ibid. |
| 67. Хүхэ нюдэн | ibid. |
| 68. Ёнгой | (Рассадин, 1987: 12) |
| 69. Араат | ibid. |
| 70. Ёнгой таабай | ibid. |
| 71. Хээрийн нохой | ibid. |
| 72. Хадны нохой | ibid. |
| 73. Уулын нохой | ibid. |
| 74. Хувхай янгирцаг | (Мэнэс, 1987: 20) |
| 75. Хамуут | ibid. |
| 76. Нохойн нагац | ibid., 22 |
| 77. Хөх нохой | (Сэр-Оджав, 1987: 46) |
| 78. Чоно бүртийнхэн | (БНМАУ-ын, 1987: 400) |
| 79. Гайхал | (БНМАУ-ын, 1987: 80) |
| 80. Бөөн цагаан | ibid. |
| 81. Сунадаг саарал | ibid. |
| 82. Борхүү боохой | ibid. |
| 83. Хэцүү нэрт | ibid. |
| 84. Их амт | ibid. |

85. Годон малгайт	ibid.
86. Мөлхөө саарал	ibid.
87. Хөнхөр	ibid.
88. Хонжигдой	ibid.
89. Саарал нохой	ibid.
90. Олон ясан янгарчуу	(Мэнэс, 1989: 90)
91. Мөлхөдөг	ibid., 118
92. Цагаан нохой	ibid.
93. Гэндэн увш	ibid.
94. Тэнгрийн нагац	ibid.
95. Өвгөлдэй	(Гаадамба, 1989: 129)
96. Тэрэм авгай	(Пунсаг, 2003: 126)
97. Модон сүүлт	ibid.
98. Заар сүүлт	ibid.
99. Өлөн чихт	ibid.
100. Хээрийн хиншүү	ibid.
101. Улимал	ibid.
102. Шилбэлцүүр	ibid.
103. Галзуу нохой	ibid.
104. Шинчи толгойтон	ibid.
105. Юндэн гэлэн	ibid.
106. Бүгээн цагаан	ibid.
107. Бурхаа	ibid.
108. Борхүү	ibid.
109. Хотон малгайт	ibid.
110. Мөхлөг толгойт	ibid.
111. Хомоол	ibid.
112. Ханжигдай	ibid.
113. Бохит	ibid.
114. Ажаа	ibid.
115. Цагаан аавын нохой	ibid.
116. Увш цэрэн	ibid.

SUMMARY

G. Menes

FROM TALE TO THE FACTS: THE IMPERIAL DYNASTIES OF THE XIONGNU AND MEDIEVAL MONGOLS AND THE REAL IMAGE OF THEIR ANCESTORS

The aim of the research is to clarify the real totemic image of the ancestors of two ruling clans of the Xiongnu and medieval Mongols. For this we quote some relevant tales from early Chinese and Mongolian written sources, give our comments on these texts. Preliminary analysis of data on 116 taboo-names for wolf, verbally recorded during field research and collected from scientific publications shows strong and very impressive remnants of the cult of the wolf among various ethnic groups of the Mongol-speaking community. From our interpretation it is evident that the real image of the totemic ancestors of the Mongolian Golden dynasty was the werewolf.